



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ




БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

“ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ” ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

“ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ” ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

НҮБ болон Монгол Улсын Засгийн газар одоогоос эхлээд 2030 он хүртэлх хугацаанд боловсролыг хувирган өөрчлөх шинэ буюу шинэчилсэн, үндэсний түвшний алс хэтийн зорилтыг тодорхойлоход тус дөхөм үзүүлэх зорилгоор оролцоог хангасан үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулахыг зорьсон. Энэхүү хэлэлцүүлгийг БШУЯ, БСҮХ зохион байгууллаа.

Үндэсний хэлэлцүүлэгт хүүхэд, залуучуудын, боловсролын, иргэний нийгмийн хэвлэл мэдээллийн үндэсний болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл болон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн төлөөлөл нийт 500 орчим хүн оролцож 5 чиглэлээр хэлэлцэж, давхардсан тоогоор нийт 1000 гаран санал гаргасан байна.



ННА 74
ДАА 370
Х-655

Эмхэтгэсэн:

У.Түяа Ph.D (Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч)

Х.Энхжаргал (Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн ЭША)

Хянан тохиолдуулсан:

М.Итгэл Ph.D (Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал)

Формат: 210x297мм

Хэвлэлийн хуудас: 1.5х.х

Хэвлэсэн тоо: 400ш

“Содпресс” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-9919-9714-7-2

Улаанбаатар хот, 2022 он.

ӨМНӨХ ҮГ

Дотоод, гадаад олон хүчин зүйлсийн нөлөөгөөр хүн төрөлхтөний өмнө тулгарч буй сорилтуудын улмаас дэлхий ертөнц улам бүр хувьсан өөрчлөгдөж байна. Энэ нь хүний хөгжлийн үндэс суурь болсон боловсролд нөлөөлж байгааг олон улс орон хүлээн зөвшөөрч, сүүлийн жилүүдэд өргөн оролцоотойгоор хэлэлцэж байгаа билээ.

БСҮХ-ийн эрдмийн хамт олон 2021, 2022 онд салбарын болон үндэсний хэмжээнд зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд боловсруулсан “Хувьсаж буй боловсрол-Ирээдүйн төлөө хамтдаа” үндэсний хэлэлцүүлгийн үр дүнг эмхэтгэн хүргэж байна. Олон талын санал, санаачилгыг тусгасан энэхүү баримт бичиг нь цаашид судлаачид, бодлого боловсруулагчид төдийгүй боловсролын төлөө сэтгэлээ чилээн буй хэн бүхэнд олон нийтийн санаа бодлыг танин мэдэхэд ач холбогдолтой юм.

“Хувьсаж буй боловсрол-Ирээдүйн төлөө хамтдаа” үндэсний хэлэлцүүлгийг “Дижитал суралцахуй ба хувирган өөрчлөлт, Хүртээмжтэй, тэгш, аюулгүй, эрүүл сургууль, Амьдрал, ажил хөдөлмөр, тогтвортой хөгжлийн төлөөх суралцах чадвар, Багш, багшийн мэргэжил, Боловсролын санхүүжилт” гэсэн агуулгын хүрээнд зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт боловсролын байгууллагаас гадна хүүхэд залуучуудын болон нийгмийн хамгааллын, ААН-ийн, бизнес эрхлэгчдийн, иргэний нийгмийн, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцож хувьсаж буй боловсролын талаар өргөн хүрээнд хэлэлцлээ. Энэхүү хэлэлцүүлгийн үр дүн нь 2022 оны IX сард НҮБ-ын Ерөнхий ассамблейн хүрээнд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерришийн ивээл дор зохион байгуулагдсан “Хувьсаж буй боловсрол” дээд хэмжээний чуулга уулзалтад Монгол Улсын танилцуулах үүрэг амлалт, санал санаачилгыг боловсруулахад чухал үүрэгтэй байсныг тэмдэглэж байна.

Дээрх үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулах үйл ажиллагаа нь боловсролын талаар хамгийн өргөн, олон оролцогчид хамтаараа ярилцаж, хэлэлцсэн онцлогтой бөгөөд хэлэлцүүлгийн оролцогчид “боловсрол бол бүх нийтийн сайн сайхан”-ны үндэс, “боловсрол бүх нийтийн зорилго” болохыг чухалчилсныг тэмдэглэж байна.

Бидний зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон бүх хүүхэд, залуучууд, байгууллагын төлөөлөл болон манлайлал үзүүлсэн БШУЯ, хамтран ажиллаж, дэмжсэн НҮБ-ын байгууллагуудад Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн талархлыг уламжилж байна.

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА ХИЧЭЭЦГЭЭЕ.

БСҮХ-ийн ЗАХИРАЛ



М.ИТГЭЛ Ph.D

ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|--------|--|
| УИХ | УЛСЫН ИХ ХУРАЛ |
| МУЗГ | МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР |
| ЗГХЭГ | ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР |
| БШУЯ | БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ |
| ЭМЯ | ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ |
| БОАЖЯ | БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ |
| ХНХЯ | ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ |
| ХХААЯ | ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ |
| СЯ | САНГИЙН ЯАМ |
| БХТЯ | БАРИЛГА ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЯАМ |
| НХХЯ | НИЙГМИЙН ХАМГААЛАЛ ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ |
| НҮБ | НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА |
| ШХА | ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ |
| БСҮХ | БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН |
| БХ | БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН |
| БҮТ | БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ |
| НТБҮТ | НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ |
| БМТТ | БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ТӨВ |
| БМДИ | БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ |
| МУБИС | МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ |
| БОМСТ | БАЙГАЛЬ ОРЧИН МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН ТӨВ |
| МҮОНРТ | МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗ |
| МХЕГ | МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР |
| ЗЦГ | ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР |
| ИНБ | ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА |
| ОНХС | ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН |
| ТЗЗҮБ | ТЕХНИКИЙН ЗӨВЛӨН ЗОХИЦУУЛАХ БАГ |
| ТХ | ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ |
| ТХБ | ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ |
| ТХЗ | ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ |
| ҮК | ҮНДЭСНИЙ КОМИСС |
| БДБ | БАГА ДУНД БОЛОВСРОЛ |
| СӨБ | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ |
| ЕБС | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ |
| ДБСБ | ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА |
| НТС | НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙ |
| СБААХ | СУРГУУЛЬ БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ АРГА ХАНДЛАГА |
| ББААХ | БАЙГУУЛЛАГА БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ АРГА ХАНДЛАГА |
| ҮТЧ | ҮЙЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ |

СЭДЭВЧИЛСЭН 5 ЧИГЛЭЛ ТУС БҮРИЙН ТАНИЛЦУУЛГА

1. ДИЖИТАЛ СУРАЛЦАХУЙ БА ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ

Дижитал суралцахуй нь боловсрол олгох, удирдах, сурган хүмүүжүүлэх ажлыг зохион байгуулахад нэгдсэн, шинэлэг хандлага юм. Энэхүү хандлагыг бий болгохын тулд хүний нөөцөө чадавхжуулах, цахим сургалтыг дэмжих технологийг нэвтрүүлэх, цахим сургалтын хөтөлбөрт нийцүүлсэн сургалт, багш, суралцагчдын цахим үр чадварыг дээшлүүлэх, хүртээмжтэй, нээлттэй сургуулийн системийг төлөвлөж, байгуулах, цаашлаад багш, суралцагчийн сайн сайхан байдал, хувийн нууц, аюулгүй байдалд цахим шилжилтээс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг сайтар судлах шаардлагатай.

COVID-19-ийн нөлөө нь улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний дотор боловсролыг хувирган өөрчлөх хэрэгцээг нийгэмд хүчтэй мэдрүүлсэн. Манай улс ч цар тахлын үед хариу арга хэмжээ авах, ирээдүйд тохиолдож болзошгүй эрсдэлт, гамшгийн нөхцөлд бэлэн байхын тулд цахим, холимог сургалтыг чанартай зохион байгуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд боловсролын салбарт цахим шилжилтийг хийж байна.

Боловсролын цахим шилжилт нь цаг хугацаа, орон зайнаас үл хамаарсан, тэгш, хүртээмжтэй боловсролын тогтолцоог бий болгох шийдэл гэж судлаачид үзэж байна. Ялангуяа хүртээмж, чанарыг сайжруулахын тулд технологид суурилсан шийдлээс гадна дижитал суралцахуйн ач холбогдол, үр ашгийг дээшлүүлэх, түүнчлэн суралцагч болон тогтолцооны түвшин дэх саад бэрхшээлийг даван туулах чадварыг бэхжүүлэхтэй холбоотой юм.

Цахим сургалтын аюулгүй, үр дүнтэй хэрэглээ, технологийн тэгш хүртээмжтэй, тогтвортой байдал нь ирээдүйн боловсролын гол стратеги юм.

Боловсролын салбарын цахим шилжилтийн хүрээнд хийгдэж буй томоохон ажлаас тоймлон танилцуулахад:

- Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд боловсролын цахим шилжилттэй холбоотой зорилтуудыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Боловсролын салбарт цахим шилжилтийг хэрэгжүүлэх үүднээс бодлого, хэрэгжилт, дэд бүтцийг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий нэгдмэл тогтолцоог бүрдүүлж эхэллээ. Үүнд: БШУЯ-д “Цахим бодлого, статистикийн хэлтэс”, БСҮХ-д “Өгөгдөл боловсруулалт, цахим судалгаа хөгжүүлэлтийн судалгааны сектор”, БЕГ-т “Цахим шилжилт, нэгдсэн статистикийн газар”, БШУЯ-ны дэргэд “Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ байгуулснаас гадна Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт мэдээллийн технологи, сүлжээ, систем хариуцсан мэргэжилтний орон тоог шинээр бий болгон хүний нөөцийг үе шаттайгаар чадавхжуулж эхэллээ.

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

- Боловсролын салбарын мэдээллийн систем, сургалтын цахим контент, удирдлагын систем, мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ болон боловсролын дата төвийн хяналт, тогтвортой ажиллагааг хангах, хөгжлийн асуудлыг төр цогцоор нь авч хэрэгжүүлж байна. Үүнд,
 - Боловсролын салбарын бүх түвшинд боловсролын удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлж, боловсролын үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж байна.
 - Багш, суралцагчид зориулсан орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсэн үндэсний цахим сургалтын MEDLE.MN платформыг хөгжүүлж, хэрэглэж эхэлсэн. Уг ажлыг цогцоор нь шийдэхийн тулд холбогдох боловсон хүчнээ чадавхжуулж байна.
- Боловсролын нэгдсэн сүлжээг үүсгэж, салбарын мэдээллийн урсгал, контентын хэрэглээний ачааллыг даан ажиллах чадамжтай мэдээллийн технологийн дэд бүтэц бүрдээд байна. Төрийн болон орон нутгийн өмчийн бүх ЕБС-ийг боловсролын нэгдсэн сүлжээнд холбосон. Энэхүү сүлжээний нийт хурд нь 4.75 Gbps байна [1].
- Төрийн өмчийн зургаан их сургуулийн суралцагчид харьяалал харгалзахгүйгээр хичээл сонгох, боловсролын зарим үйлчилгээг авах боломжтой болсон.
- COVID-19 цар тахлын улмаас багш нар цахим ур чадвараа сайжруулж, зайнаас ажиллах арга зүйд богино хугацаанд суралцан, өөрсдийн боломж, мэдлэгт тулгуурлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулж, зохих хэмжээний туршлага хуримтлуулсан байна. Мөн багшийн МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлага (БШУ-ны Сайдын А/67, 2020.02.05) багшийг чадавхжуулах удирдамжийг баталсан [2].
- Цахим, танхим, холимог сургалтын хэлбэр, 5/9 зарчимд тулгуурласан менежментийг хэрэгжүүлсэн [3].
- Төр, хувийн хэвшлийн түншлэл бэхжсэн. Тухайлбал, үүрэн телефоны үндэсний дөрвөн оператор нийгмийн хариуцлагын хүрээнд суралцагч, багш нарт цахим сургалтын системийн орчинд дата унахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.

Тулгамдаж буй асуудлууд

Цар тахлын үе дэх дижитал хуваагдал нь олон суралцагчийг зайн сургалтад хамрагдаж чадахгүй байх улмаас сургалтын хоцрогдлын нөхцөлийг улам бүр хүндрүүлж байна.

Боловсролын хувьсаж буй нөхцөл дэх дижитал суралцахууд анхаарах гол асуудлууд нь:

- **Дижитал хуваагдалд** ихэвчлэн газар зүйн байршил, дэд бүтэцгүй орчинд амьдарч байгаа болон санхүүгийн боломж, цахим ур чадвар, хүйс, тусгай хэрэгцээт, хэл, соёлын ялгаатай иргэд өртөж байна.
 - COVID-19 цар тахлын үед Монгол улсын 330 сумын сургуулийн 172,300 сурагч, 46 багийн сургуулийн 6,277 сурагч, нийт 178,577 сурагч дэд бүтэцгүй, алслагдсан, интернэтгүй, цахилгаангүй, техник хэрэгсэлгүй гэх мэт шалтгаанаар цахим сургалтад хамрагдах боломжгүй [4].

- ЕБС-ийн нийт суралцагдын 4-6 хувь (орон нутгийн онцлогоос хамааран харилцан адилгүй) нь теле хичээл огт үзэх боломжгүй буюу мэдээлэл технологийн хэрэгсэл ашиглах боломжгүй (огт байхгүй эсвэл ажиллахгүй) байв. Тухайлбал, аймаг, сумын төвөөс ихэвчлэн алслагдан амьдардаг малчдын хүүхдүүд, өвөлжилт, хаваржилт хүндэрснээс хичээлд хамрагдах боломжгүй, оторт гарсан, салхи, шуурганаас үүдэн сүлжээ тасарсан, суурин газруудад интернэт, кабелийн төлбөрөө төлөх боломжгүй эсвэл мэдээлэл технологийн хэрэгсэлгүй, орлогын
- түвшин доогуур өрхийн болон үндэсний цөөнхийн хүүхдүүд өртөх нь нийтлэг байна. Улсын дунджаар теле хичээл үзэлтийн хувь 81 байв [5].
- Гэр бүлийн орчин нөхцөл, 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхөд теле хичээлийн цагийн давхцал, тусгай хэрэгцээт хүүхдийн онцлогоос хамааран хичээлийг бүрэн үзэж чадахгүй байх зэрэг бэрхшээл байсан [5].
- Цахим сургалтад хамрагдах боломжтой ч хэрхэн боловсролын үйлчилгээ авч, үр ашгийг хүртэх тал дээр суралцагчдын үр чадварын ялгаа байсаар байна [2]. Техник ашиглалтын чадвар, цахим сургалтын системд ажиллах чадвар сул, энэ талын дэмжлэггүйгээс хамрагдаж чадахгүй байна.
- Боловсролын салбарыг цахимжуулахтай холбоотой бодлого, төлөвлөгөө хэрэгжиж буй боловч илүү сайжруулах хэрэгцээ байгааг “Боловсролын салбар дахь мэдээлэл харилцаа холбооны технологийн тойм шинжилгээ”-д тэмдэглэсэн байна.
- **Бүх нийтийн цахим үр чадвар**
 - *Багшийн цахим үр чадвар* сул байна. Судалгаагаар нийт багшийн 73.3 хувь нь зайн сургалтаар хичээл заасан туршлагагүй, 20 хувь нь цахим хэрэгсэл ашиглаж мэдэхгүй гэсэн байна [6].
 - *Суралцагчдын зайнаас, цахимаар суралцахад нэн шаардлагатай цахим үр чадвар*, бие даан суралцах чадварыг хөгжүүлэх хэрэгцээтэй [7].
 - *Эцэг, эхийн цахим үр чадвар хангалтгүй*, хүүхдийнхээ биен даан суралцах үйлд дэмжлэг үзүүлэх бэлтгэл сул байна [5].
- **Боловсролын салбарын МХТ-ийн дэд бүтэц** дутмаг байна. Төрийн болон орон нутгийн өмчийн бүх ЕБС-иудыг холбон боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгосон хэдий ч хичээлийн болон дотуур байр, цэцэрлэгүүд бүрэн интернэтэд холбогдоогүй байна. Мөн дотоод сүлжээний орчин бүрдээгүй, ЕБС-д сүлжээ хариуцсан мэргэжилтэн ажиллах орон тоо байхгүй, цалин бага учраас сургуульд мэргэжлийн хүн ажиллахгүй байгаа зэрэг хүний нөөцтэй холбоотой бэрхшээл бий [2].
- **Боловсролын нээлттэй нөөц материал** (цахим сурах бичиг, теле хичээл, аудио, видео, цахим хичээл, контент, интерактив, бие даан суралцах дасгал ажлын

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

- дэвтэр гэх мэт)-уудыг хөгжүүлж байгаа ч хэрэглэгчийн хандалт учир дутагдалтай, боловсролын бүх түвшний суралцагчдад зориулсан нэгдсэн сан үүсгээгүй байна.
- **Өгөгдөл, мэдээллийн найдвартай байдал, ашиглалт сул.** Боловсролын технологийн хөгжилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бодит цаг хугацааны анхдагч өгөгдөл, мэдээлэл нь тодорхой бус, бүрэн бус байна.
 - **Цахим сургалтад шилжсэнээр суралцагчийн харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн өөрчлөлттэй холбоотой нийгэм-сэтгэл зүйн асуудал [8], цахим донтолт, дээрэлхэлт, онлайн хүчирхийлэлд өртөх, кибер аюулгүй байдалтай холбоотой эрсдлийг нэмэгдүүлж байна.**

Шийдвэрлэх арга зам

Суралцахуйг сэргээх – Дижитал суралцахуй

Цар тахлын дараах сургуулиудыг аюулгүй, нээлттэй байлгах сурлагын хоцрогдлыг арилгахад XXI зууны иргэдийн үр чадварт суралцагчдыг (тоо бодох, унших, дижитал чадвар гэх мэт) сурах нөхцөлийг бүрдүүлэх дижитал технологийг ашиглах, тэгш байдлыг хангах, бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Уламжлалт танхимын сургалтыг өргөжүүлэх, чанартай цахим болон холимог сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ бодитойгоор тулгарлаа.

Танхимын сургалтын үйл ажиллагааг сэргээх, хоцрогдлыг арилгахад дижитал технологийг ашиглахад дараах өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй байна. Үүнд:

- **Багшийг чадавхжуулах, сургалтад хамруулах, цахим үр чадвар, заах арга зүйн чиглэлээр** зайн болон цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулж, тасралтгүй хөгжүүлэх чадварыг дэмжих. Түүнчлэн багш нар хамтран суралцах, ажиллах, мэдлэг, үр чадвараа харилцан хуваалцах хамтын ажлын нэгдлийг дэмжих.
- **Сургалтын агуулга, нөөцийн уян хатан байдал** нь ялгаатай бүлгийн суралцагчдад нийцсэн байх. Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүнийг суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, нээлттэй, цахим, зайн сургалтын үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлж, хүртээмжтэй хүргэх.
- **Хүртээмжтэй, уян хатан байдлыг хангахуйц дэд бүтэц, сүлжээ, тоног төхөөрөмж.** Бүх суралцагчдыг технологид суурилсан сургалтад бүрэн оролцуулахын тулд интернэт болон тоног төхөөрөмжүүдээр хандах боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Үүний тулд дэд бүтцийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төхөөрөмжөөр хангах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр нэмэлт арга хэмжээ авах хэрэгтэй байна. Улмаар цахим хэрэгслээр дамжуулан тэгш боломжоор хангуулж чадахгүй байгаа суралцагчдад зориулсан хамгийн хүртээмжтэй хувилбарыг хөгжүүлэх.
- **Дижитал технологид суурилсан боловсрол аюулгүй, үр дүнтэй суралцахуйг дэмжих.** Суралцагчдад аюулгүй цахим орчныг бүрдүүлэх, хамгаалалтын арга хэмжээг бий болгох нь чухал байна. Үүний тулд урьдчилан сэргийлэх ажлуудыг

зохион байгуулах, тэдгээрт өгөгдөл эзэмших, ашиглах, хэрэглэгчийн нууцлал, боловсролын технологийг ёс зүйтэй ашиглах зэрэг нь багтана.

- **Олон нийт, гэр бүлийн дэмжлэг.** Эцэг эх, гэр бүлийн гишүүдийг хүүхдийн сурах үйл явцад идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Дижитал технологи нь сургуулиудад гэр бүл, олон нийтийн бүлгүүдтэй харилцах харилцааг бэхжүүлэх, тухайлбал, сурагчдыг ангидаа эргэн очих нөхцөлийг бий болгох, суралцах хүсэл тэмүүллийг нь нэмэгдүүлэх, олон нийтийн дэмжлэгтэй уян хатан хөтөлбөрүүдийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Хувьсаж буй боловсрол - Дижитал суралцахуй

Дижитал суралцахуй нь илүү тэгш, хүртээмжтэй, уян хатан байж, XXI зууны үр чадварыг төлөвшүүлэхийн тулд бүх хүүхдэд анхаарлаа төвлөрүүлэхийн зэрэгцээ, цахим шилжилтэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургах арга зүйн инновацийг хөгжүүлэх, боловсролын үйлчилгээг цахимжуулна. Дижитал боловсролын тогтолцоог хөгжүүлэх чиглэл:

- **Насан туршдаа тасралтгүй суралцах, боловсрох хэрэгцээг нээлттэй, цахим, зайн сургалтаар хангах боломжийг бүрдүүлсэн цахим боловсролын тогтолцоог бий болгох.** Үүнд:
 - Цахим боловсролын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх.
 - Цахим шилжилтийн бодлого зохицуулалтыг боловсруулах (цахим шилжилтийн урт, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай санхүүжилт, нөөцийг дайчлах замаар дэмжих).
 - Цахим сургалтаар эзэмшсэн боловсролын үр дүнг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх механизмыг бий болгох.
- Бүх түвшний боловсролын салбарын мэдээллийн системийг (EMIS) бүрэн хөгжүүлснээр салбарын бодлого, **төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ** хийх үйл ажиллагаанд хэрэглэж хэвших, өгөгдөл, мэдээллийн хүртээмж, аюулгүй байдлыг бүрдүүлэх.
- Бүх шатны боловсролын байгууллагын багш, сурган хүмүүжүүлэгч, удирдах ажилтнуудын **цахим үр чадварыг системтэйгээр дээшлүүлэх.**
- **Дижитал технологийн нөлөөгөөр бий болсон суралцахуйн инновацийг хөгжүүлэх.** Үүний тулд:
 - Цахим сургалтын удирдлагын системийг (LMS) хөгжүүлэх,
 - Холимог болон цахим сургалтад тохирсон сургалтын хөтөлбөр, багшлахуйн арга зүй, үнэлгээг боловсруулах,
 - Боловсролын чанартай, нээлттэй нөөц материалын хүртээмжийг нэмэгдүүлэх,
 - Боловсролын, сургалтын үйл ажиллагаанд интерактив, мультимедиа болон бусад хэрэгслийг ашиглах.

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

- *Нийтийн сайн сайхны төлөөх түншлэл бий болгох.* Цахим шилжилтийн санаачлагыг дэмжих мэдлэг, агуулга, нөөцийг хуваалцахыг дэмжих зорилгоор олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх. Олон нийтийг татан оролцуулж, боловсролыг нийтийн сайн сайхан асуудал болгоход чиглэсэн засаглалын зохих механизмаар удирдан чиглүүлэх.
- *Бүх нийтэд дижитал иргэншлийн боловсрол олгох.* Дижитал иргэн болгон хөгжүүлэх, аюулгүй, ёс зүйтэй, утга учиртай технологи ашиглах боловсрол олгох. Мөн дижитал нөөц, хэвлэл мэдээлэл, мэдээллийн ашиглалт, дүн шинжилгээ хийх, бие даан суралцах
 - ур чадварыг бий болгох, цахим сургалтад хамрагдахад суралцагчдыг дэмжих зэрэгт анхаарал хандуулах.

Эх сурвалж:

- [1] UNICEF, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтад бахим платформ ашиглах боломж, нөхцөл байдлын судалгаа, Улаанбаатар, 2020.
- [2] UNESCO. БШУЯ, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн зорилго-4”-ийн хэрэгжилтийн ахиц дэвшлийн тойм үнэлгээ (2016-2021), Улаанбаатар, 2022.
- [3] БШУЯ, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө (2021-2023), Улаанбаатар, 2021.
- [4] Боловсролын хүрээлэн. БШУЯ, Сургууль завсардаж болзошгүй хүүхдийг илрүүлэх судалгааны тайлан, Улаанбаатар, 2021.
- [5] UNICEF. IRIM. БШУЯ, Онцгой байдлын үеийн теле хичээл, түүний үр дүн тохиромжтой байдал, Улаанбаатар, 2020.
- [6] БШУЯ, Ковид19-ийн боловсролын салбарт үзүүлж буй үр нөлөөг бууруулахад чиглэсэн бодлого, тайлан мэдээлэл, Улаанбаатар, 2021.
- [7] БШУЯ, Дээд боловсролын сургалтын байгууллагын цахим сургалтын орчин, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн тайлан, Улаанбаатар, 2021.
- [8] МУИС. UNICEF. БШУЯ, Хүүхдийн нийгэм сэтгэл зүйн асуудал, эрсдлийг илрүүлэх судалгааны тайлан, Улаанбаатар, 2020.
- [9] UNESCO, Залуучууд, насанд хүрэгчдийн суралцахуйг дэмжих нээлттэй, зайны сургалт. Ковид 19-ийн эсрэг ЮНЕСКО-ийн боловсролын салбарын хариу арга хэмжээ, боловсролын онцлох асуудлууд, Асуудал №2,5-2020/06, Улаанбаатар, 2020.
- [10] UNESCO, “Монгол улсын боловсролын салбар дахь Мэдээлэл харилцаа холбооны технологийн бодлогын тойм шинжилгээ,” Улаанбаатар, 2021.

- [11] UNESCO, Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ, Улаанбаатар, 2019.
- [12] УИХ, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улаанбаатар, 2020.
- [13] УИХ, Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар, 2020.
- [14] БСШУСЯ, Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь төслийн эцсийн үнэлгээний тайлан, Улаанбаатар, 2017.
- [15] БСШУСЯ, БҮТ. Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх судалгааны эцсийн тайлан, Улаанбаатар, 2021.
- [16] БШУЯ, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030), Улаанбаатар, 2020.
- [17] ЦХХХЯ, Цахим үндэстэн дунд хугацааны зорилтот хөтөлбөр 2022-2027, Улаанбаатар, 2021.
- [18] Transforming Education Summit, “Futures of Education Briefing Notes, Улаанбаатар, 2022.
- [19] OECD, 21st-Century readers developing Literacy Skills in a Digital World, 2021.
- [20] БСШУСЯ. БХ. UNESCO, Монгол Улсын боловсролын сүүр мэдээллийн тайлан, Улаанбаатар, 2019.
- [21] UNESCO, Remaining our futures together a new social contract for education, 2021.

2. ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ

Боловсролд тэгш хамруулах, хүртээмжтэй байх нь ТХЗ 4-ийн үндсэн зорилт бөгөөд Монгол Улс уг зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого, стратегийг үндэсний хөгжлийн бодлогодоо тодорхойлон хэрэгжүүлж байна. Тухайлбал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2030 он гэхэд хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэл хийхээр зорьж байна [1]. *Тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй сургууль нь “бүх суралцагчийн боловсролын үйл ажиллагаан дахь тэгш хамралт, оролцоог хангасан, аливаа ялгаварлан гадуурхалтгүй, ялгаатай хэрэгцээндээ нийцүүлсэн боловсролын үйлчилгээг [2] сурч, хөгжихөд таатай, ээлтэй, үнэт зүйлс, соёлыг бий болгосон орчинд авах боломжийг хангасан байх”* тухай ойлголт юм. Суралцагч бүр хүлээн зөвшөөрөгддөг, хүндлэгддэг, үнэлэгддэг гэдгээ мэдрэх боломж олгосон тэгш хүртээмжтэй, эрүүл аюулгүй орчинд бага наснаасаа эхлэн чанартай боловсролыг эзэмшиж чадвал нийгэмд тулгарч буй цаашдын асуудал багасаж, олон салбарын тэгш бус байдал арилна.

Манай Улс тэгш хамран сургах боловсрол, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй болон бусад ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролд анхаарал тавьж, сүүлийн жилүүдэд бодлого, эрх зүйн хувьд цогц байдлаар хандаж байна. 2016 онд Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиуд батлагдаж суралцагчийг аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, үл хайхрах байдал, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн цэцэрлэг, сургууль, дотуур байрны орчны аюулгүй байдал, үйлчилгээний стандарт зэрэг бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэхэд тодорхой ахиц гарсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшийг 2013 оноос Монгол Улсын Боловсролын Их Сургуульд тусгайлан бэлдэж ирлээ. Мөн ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлогт нийцүүлэн элсэлтийн ерөнхий шалгалтын журмыг сайжруулан боловсронгуй болгож байна. Сургуулийн өмнөх боловсрол олгохтой холбоотой нүүдлийн гэр цэцэрлэг, ээлжийн бүлэг, явуулын багш, ээлжийн багш, хувилбарт сургалтын үйлчилгээ бий болгосон ололттой тал байна [3]. Сургууль дээр сурагчдад эрүүл, шим тэжээлт хоол хүнсээр үйлчлэхийн тулд “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон өргөжүүлсэн [4].

КОВИД-19 цар тахлын үед үндэсний хэмжээнд 16 телевизийн суваг болон econtent.edu.mn сайтаар дамжуулан нийт 5284 теле хичээлийг бэлтгэн суралцагчдад хүргэсний зэрэгцээ алслагдсан сум, багийн сургуулийн болон боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд хэвлэмэл болон тохируулгат материал боловсруулан хүргэж, зайнаас суралцах боломж олгосон [5]. Мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагууд өөрсдийн нөөц боломжид суурилан цахим хэлбэрээр сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан, цахим сургалтын чанарыг сайжруулах тал дээр арга хэмжээ авч ажилласан [6] байна. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор ерөнхий

боловсролын сургуулийн сургалтыг 5:9 зарчмаар танхим болон зайнаас хичээллүүлсэн нь олон улсад сайн туршлага хэмээн үнэлэгдсэн байна. Эдүгээ сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, суралцахуйг дэмжих сургалт үйл ажиллагааг хэрэгжүүлэх, сургуульд эргэн ирэх, дасан зохицох цогц төлөвлөгөөг гурван үе шаттай төлөвлөн хэрэгжүүлж байна [5].

Тулгамдаж буй асуудлууд

Монгол Улсад боловсролын хамран сургалт өндөр байгаа боловч хүүхэд бүр өөрт тохирсон чанартай боловсролын үйлчилгээг зохих түвшинд авч чадахгүй байна. Газар зүйн байршил, хэл соёлын ялгаа, хөгжлийн бэрхшээл, үндэсний цөөнх, нийгэм эдийн засгийн ялгаа, жендэр, бэлгийн болон хүйсийн баримжаа, шилжилт хөдөлгөөн зэрэг нь боловсролын бүх түвшинд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ авахад нөлөөлж байна. 2021-2022 оны хичээлийн жилд амьдралын гачигдал, хөгжлийн бэрхшээл, өвчин, ажил эрхлэх, сурах дүргүй байх зэргээс шалтгаалан 6-14 насны сургуулиас гадна байгаа буюу сургуульд огт ороогүй 967, сургуульд ороод завсардсан 204 хүүхэд байна [7]. Мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд тэгш хамран сургах асуудлыг нарийвчлан судалсан, ялгаатай хэрэгцээтэй оюутанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, учирч буй саад бэрхшээлтэй холбоотой судалгаа, мэдээлэл харьцангуй хомс байна.

КОВИД-19 цар тахлын үед хичээл, сургалтын үйл ажиллагааг зайнаас зохион байгуулах хугацаанд теле хичээл болон их, дээд сургуулийн онлайн хичээлийг тасралтгүй үзэх боломж суралцагч бүрд харилцан адилгүй, тэдний онцлог хэрэгцээнээс хамаарсан хичээл, сургалтууд явагдах боломж хязгаарлагдмал байсан нь хичээл, сурлагын хоцрогдол үүсгэж, суралцагчдын нийгэмшихүйн чадвар, суралцахуйн чанарт сөрөг нөлөө үзүүлсэн нь судалгаагаар илэрсэн юм.

- **Ядуурлын өсөлт ба суралцахуй дахь нийгэм, эдийн засгийн ялгаа:** Цар тахлын үеийн өрхийн эдийн засгийн нөхцөл байдал нь суралцагчийн боловсролд нөлөөлж, ялангуяа ядуу өрхийн хүүхдүүд боловсролын тасалдал, суралцахуйн хоцрогдолд илүү өртсөн байх эрсдэлтэй байна.
- **Алслагдсан байдал:** Малчин өрхийн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал болон сургууль завсардалт тулгамдсан асуудал болж байна. Цар тахлын үед теле болон онлайн хичээлийн хүртээмж хамгийн бага хүрсэн хэсэг нь малчин, төв сууринаас алслагдсан, орлогын түвшин доогуур болон эцэг эхийн анхаарал халамж сул өрхийн суралцагчид байна [8]. Үүнд мэргэжлийн болон их, дээд сургуулийн оюутнууд мөн багтаж байна.
- **Хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээл:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын сурах эрх зүйн орчин сайжирч, нийгмийн хандлага өөрчлөгдөж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хамран сургалт харилцан адилгүй, бодлого, журмын хэрэгжилт жигдрээгүй байна [9]. Одоогийн байдлаар цэцэрлэгт хамрагдах насны 1629 хүүхдээс 1023 буюу 63.0 хувь нь, 6-17 насны 8873 хүүхдээс 6208 буюу 70.7 хувь нь боловсролд хамрагдаад байна. Их, дээд сургуульд хөгжлийн

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

бэрхшээлтэй 400 оюутан, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад 777 суралцагч суралцаж байгаа тоон мэдээлэл байгаа хэдий ч боловсролын үйлчилгээнээс гадна үлдсэн суралцагч байсаар байна. Суралцагчдын хөгжлийн хоцрогдол болон бэрхшээлийн эрт илрүүлэлт хангалттай бус байгаагаас тэдэнд шаардлагатай дэмжлэгийг оройтуулж байна.

- **Хэл соёлын ялгаа:** Хичээлийн хэл (ихэвчлэн үндэсний, албан ёсны хэл) нь суралцагчийн гэрт хэрэглэж буй хэлээс ялгаатай үед үндэсний цөөнхийн хүүхдийн хэл яриа, хөгжлийн чадвар бусад хүүхдүүдээс хоцрох шалтгаан болдог.

Жендер: Сургууль завсардаж болзошгүй эрсдэлд байгаа бага боловсролын 965 сурагчийн 67.0 хувь нь эрэгтэй, суурь боловсролын 825 сурагчийн 63.0 буюу 76.0 хувь нь эрэгтэй, бүрэн дунд боловсролын 141 сурагчийн 113 буюу 80.0 хувь нь эрэгтэй байна [10]. Жендэрийн харьцааг 1 эрэгтэй суралцагчид ногдох эмэгтэй суралцагчдын тоогоор, 2021 оны байдлаар авч үзвэл техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын хүйсийн харьцаа нь 0.7, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын хүйсийн харьцаа 1,6 байна [3]. Хөвгүүдийн боловсролд бага анхаарч, бүрэн дунд боловсролоос завсардуулан, үр чадвар бага шаардах ажилд эрт оруулах хандлага амьжиргааны түвшин доогуур, ялангуяа, малчин өрхүүдэд түгээмэл байна. КОВИД-19 хөл хорионы үед хүүхэд, өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой асуудал (жирэмслэлт, үр хөндөлт, БЗДХ) болон гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн тохиолдол нэмэгдсэн нь сургуульд буцаж ирэх, суралцах боломжид нөлөөлсөн.

- Эрүүл, аюулгүй сургалтын байгууллага: “КОВИД-19 цар тахлын үеийн хөл хорио нь суралцагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж ганцаардах, уйтгарлах, бүхмидалтай болох,
- сурлагаар хоцрогдохоос айх зэрэг сөрөг үр дагавар үүсэхэд хүргэсэн ба харилцаа,
- сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлд гарч буй асуудлууд нь цаашид удаан үргэлжилбэл тэдний бие махбод, танин мэдэхүй,

нийгэмшихүй болоод бие хүний хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй байна” [11] гэжээ. Мөн эрсдэлийн үнэлгээгээр ерөнхий боловсролын 177 сургууль буюу 31% нь дунд эрсдэлтэй, 64 сургууль буюу 11.4% нь их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн [12]. Улаанбаатар хотын 9 дүүргийн ЕБС-ийн 11-16 насны 1,236 суралцагчийг хамруулан хийсэн судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдагсдын 37.9 хувь нь ямар нэг байдлаар дээрэлхүүлж, доромжлуулсан, 40.7 хувь нь бусад хүүхдийг зодуулж дээрэлхүүлж байхыг харсан бол 80 гаруй хувь нь дарамтлуулж, шоовдорлуулсан, ямар нэг асуудал гарахад хаана, хэнд хандахаа мэддэггүй гэж хариулсан байна [13]. Эдгээр тоо баримтаас харахад орчны аюулгүй байдлын стандарт, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилт нэгж байгууллагын түвшинд хангалтгүй байна гэж үзэж болохоор байна. Мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын зарим байгууллагын

багш, ажилтнууд, оюутан суралцагчдын дунд дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт зэрэг сэтгэл зүйн сөрөг үүр амьсгал оршоор байна.

Цэцэрлэг, сургууль, дотуур байрны дэд бүтэц, тоног төхөөрөмж, хоол үйлдвэрлэл, төвлөрсөн усан хангамж, ариун цэврийн байгууламжтай холбоотой асуудлууд, ялангуяа хөдөө орон нутагт бүрэн шийдэгдэж чадаагүй байна. Тухайлбал, 357 сургууль буюу нийт сургуулийн 52.3%, 220 цэцэрлэг буюу 22.9%, 242 дотуур байр буюу 45.2% гаднаа нүхэн жорлонтой байна [3]. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сургууль, сургалтын байгууллагын орчинд саадгүй нэвтрэх, аюулгүй зорчих боломжийг бүрдүүлэхийг чухалчлан сургуулиуд дэд бүтцийн өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн боловч тоон үзүүлэлтийн талаарх мэдээлэл хангалттай бус байна.

Шийдвэрлэх арга зам

Цар тахлын дараа суралцагчдыг сургуульдаа эргэж ирэх, суралцах боломжийг нь хангахын тулд тусгай арга хэмжээ авах шаардлагатай байна. Сургалтын байгууллага бүр суралцахаар ирж буй суралцагч бүрт үйлчлэхэд бэлэн, нийгэм сэтгэл зүйн болон материаллаг орчны хувьд эрүүл, аюулгүй байдлыг хангаж, суралцагчдынхаа давуу тал болон хэрэгцээ шаардлагад тохируулан зохистой байдлаар хариу үйлдэл үзүүлэх боломжтойгоор хувьсан өөрчлөгдөх цаг үе ирсэн байна.

Тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй сургуулийн төлөө

- Сурлагаар хамгийн их хоцорсон суралцагчдыг тодорхойлох, оношлох, үнэлэх: Боловсролын бүх түвшинд цар тахлын нөлөөнд хамгийн их өртсөн, боловсролын байгууллагын гадна үлдсэн суралцагчдын суралцахуйн алдагдлыг тодорхойлох, хэмжих, сургалтын ахиц дэвшлийг илрүүлэх болон нэгтгэн дүгнэх зорилгоор суралцагчийн үнэлгээний хэрэгслийг боловсруулах ашиглах, илүү нээлттэй, уян хатан үнэлгээ, баталгаажуулалтын бүтэц, тогтолцоог хөгжүүлэх;
- Суралцагчдын хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх: Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан суралцахуйн хоцрогдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилго бүхий тэгш хамран сургах, уян хатан, тохируулгат сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- Сургууль, сургалтын байгууллага бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх: Сургуулийн болон орон нутгийн хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд суралцагч, багш, ажилтнууд, эцэг эх, олон нийт, байгууллага, орон нутгийн оролцоо, хамтын ажиллагааны чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх, нөөцийг үр ашигтай ашиглах замаар суралцахуйн орчныг хувирган өөрчлөх;
- Суралцагчдад нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх: Суралцагчийг ойлгох, сэтгэл зүйн хямрал, гутрал, тогтворгүй байдлыг даван туулах, сурч, хөгжихөд нь олон талын оролцоонд тулгуурласан нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх;

Тэгш, хүртээмжтэй, эрүүл аюулгүй боловсролын тогтолцоог бий болгохын төлөө:

- Дижитал суралцахуйг оролцуулаад суралцагч өөртөө тохирсон хэлбэрээр боловсрол эзэмших арга замыг нээх, тухайн хэлбэрээр эзэмшсэн боловсролыг нь хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах;
- Боловсролын төсөв, төлөвлөгөөг ялгаварлан гадуурхалгүй, тэгш боломжоор хангасан, зорилтот стратегиар боловсруулж, хэрэгжүүлэх, боловсролын салбар дахь хүүхэд хамгаалалд төсөв хуваарилан, үйлчилгээний чанар, өгөөжийг нэмэгдүүлэх;
- Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын талаарх эцэг эх, асран хамгаалагч, олон нийт, ялангуяа боловсролын салбарын мэргэжилтнүүдийн ойлголт хандлагад анхаарлаа хандуулах, багш нарыг чадавхжуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх;
- Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэх;
- Тэгш хүртээмжтэй, чанартай боловсролын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур аргачлалыг тусгайлан боловсруулж, боловсролын албан ёсны мэдээллийн санд тэдгээртэй холбоотой өгөгдөл мэдээллийг цуглуулж, нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Онцгой байдлын үед боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх, бэлэн байдлын цогц төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;

Эх сурвалж:

- [1] Монгол Улсын Засгийн Газар. (2019). “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.
- [2] INCLUSIVE EDUCATION: THE WAY OF THE FUTURE” International Conference Centre, Geneva, 2008
- [3] БШУЯ, ЮНЕСКО. (2022). Монгол улсын “Тогтвортой хөгжлийн зорилго - 4”-ийн хэрэгжилтийн ахиц дэвшлийн тойм үнэлгээ (2016-2021).
- [4] Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 450 дугаар тогтоол.
- [5] БШУЯ, БХ, АХБ. (2021). ЕБС-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж.
- [6] БШУЯ. (2021). Дээд боловсролын сургалтын байгууллагын цахим сургалтын орчин, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн тайлан
- [7] БМТТ. 2021-2020 оны хичээлийн жилийн статистик.

- [8] БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан, IRIM. (2020). Онцгой байдлын үеийн теле хичээл, түүний үр дүн, тохиромжтой байдал. Судалгааны тайлан.
- [9] БСШУЯ. (2019). Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдыг боловсролд тэгш хамруулах нь. Судалгааны тайлан.
- [10] БШУЯ, БСҮХ (2021). Сургууль завсардаж болзошгүй хүүхдийг илрүүлэх судалгааны тайлан.
- [11] БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан, МУИС. (2020). Хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх судалгаа.
- [12] БШУЯ (2019). ЕБС-ийн орчны эрсдлийн үнэлгээ.
- [13] Хүүхдийг ивээх сан (2017). Өсвөр үеийнхний дуу хоолой.

3. АМЬДРАЛ, АЖИЛ ХӨДӨЛМӨР, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ СУРАЛЦАХУЙ БА УР ЧАДВАР

Дэлхийн хүн ам 2050 он гэхэд 10 тэрбумд хүрнэ гэсэн тооцоо байгаа бөгөөд байгалийн нөөц, биологийн төрөл зүйлийн хорогдол, уур амьсгалын огцом өөрчлөлт, цэвэр усны хомсдол, халдварт өвчин, хүний эрүүл мэндэд үзүүлж буй хотжилт, суурьшмал амьдралаас үүсэлтэй бохирдлын нөлөө зэрэг дэлхий ертөнцөд хүн төрөлхтний үлдээж буй үл мөрийг бууруулахад хариуцлагатай, оролцоотой, аливааг эргэцүүлж, шүүн тунгаах чадвартай иргэдийг бэлдэх шаардлага тулгарч байна [1]. Иймд хүн төрөлхтөн болон дэлхийн ертөнцийн сайн сайхны төлөө идэвхтэй, бүтээлчээр хувь нэмрээ оруулахын зэрэгцээ тодорхойгүй, ээдрээтэй ирээдүйд бэлтгэгдсэн, уян хатан, дасан зохицох чадвар бүхий мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлагатай суралцагчийг хөгжүүлэхийг боловсролын хувьсаж буй өөрчлөлт гэж үзэж байна [2]. Эдгээр мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлд: шүүмжлэлт сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар, хүн хоорондын харилцааны чадвар, зөрчлийн менежмент, бүтээлч сэтгэлгээ, системийн сэтгэлгээ, хамтаар ажиллах чадвар, бусдын оронд өөрийгөө тавьж үзэх, сэтгэл хөдлөлөө удирдах чадвар, дижитал болон техникийн чадвар, STEM чадвар, ногоон үр чадвар, хариуцлагатай дэлхийн иргэн байх, инноваци болон бизнес эрхлэх чадвар, иргэний болон үлс төрийн оролцоо, насан туршдаа суралцах чадвар мөн цөм үнэт зүйлс болох шударга ёс, хүний эрх, тэгш байдал зэргийг хамруулан үзэж болно [2].

Олон улсын судалгаагаар өнөөдөр ЕБС-д сурч байгаа сурагчдын 65 хувийг урьд нь хэзээ ч байгаагүй шинэ ажлын байр угтах бөгөөд [3] 2030 он гэхэд дэлхийн хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагааны 50 орчим хувийг хиймэл оюун ухаан, робот гүйцэтгэх төлөвтэй байна [1]. Технологийн дэвшилд суурилсан аж үйлдвэрийн хувьсгалын энэ эрин үед гар ажиллагаа шаардсан нэг үйлдэлт ажлыг автоматжуулснаар, ажлын байранд эрс өөрчлөлт гарч, бүтээлчээр сэтгэх, хамтдаа асуудал шийдэх, технологи ашиглан мэдлэг, инновац бүтээх чадвар шаардсан ажлын байр илүү их болж байна [4]. Хэдийгээр технологийн дэвшил давамгайлах төлөвтэй байгаа ч дараагийн 10 жилд нийгэмшил-сэтгэл хөдлөлийн чадвар хөдөлмөрийн зах зээлд чухал нөлөө үзүүлнэ гэдгийг судалгааны үр дүн онцолжээ [5].

Дээрх хэрэгцээтэй үр чадварын тухайд манай улсын боловсролын салбарын зарим ололт, амжилтаас дурдвал:

СӨБ, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдөж буй дээрх чадваруудын туссан байдлыг шинжилж үзэхэд эргэцүүлэн бодох, бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх, харилцах, бие даан суралцах, өөрийгөө хөгжүүлэх, багаар болон хамтарч ажиллах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар, мэдээллийн технологи хэрэглээний (мэдээлэл харилцааны технологиор мэдээлэл олж авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ёс суртахуунтай хэрэглэх) чадвар тусгагдсан байна [6]. Мөн тогтвортой хөгжлийн боловсролын зорилт, арга зүй, цогц чадамжийг сургалтын хөтөлбөрт тусгаснаар

сурагчид тодорхой хичээлийг судалсны үр дүнд тогтвортой хөгжлийн үзэл санаа шингэсэн мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх боломж, нөхцөл бүрджээ [7].

21 дүгээр зууны Монгол суралцагчийн “Тоонон” загвар суралцагчийн цогц чадамжийн хүрээг тодорхойлж, “21 дүгээр зууны монгол суралцагчийн цогц чадамж”-ийг боловсролын түвшинд тохируулан боловсруулсан [8]. Энэхүү цогц чадамжийн хүрээ нь олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдөж буй дээрх чадваруудтай нийцэл сайтай боловсруулагджээ.

МТБСБ-ын төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор элсэлт-сургалт-төгсөлтийн бүхий л үе шатанд нийгмийн түншлэлийг хөгжүүлэн мэргэжлийн холбоодын үүрэг оролцоог нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлсний дүнд тодорхой ахиц гарсан бөгөөд цар тахал нөлөөлсөн хэдий ч огцом бууралтгүй тогтвортой хадгалагдаж байна [9].

ДБСБ-ын төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор АХБ-ны санхүүжилтээр БШУЯ-наас 2012-2019 онд хэрэгжүүлсэн “Дээд боловсролын шинэчлэл төсөл” салбарын хэмжээнд томоохон өөрчлөлт авчирсан. Энэ төслийн хүрээнд 2014 оноос сургалтын хөтөлбөрийг шинэчлэхдээ суралцагчдад шинийг эрэлхийлэх, асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах, системтэйгээр төлөвлөх, багаар ажиллах, бичгээр болон цахим, мультимедиа, график дүрслэлээр тайлагнах, харилцах, гадаад хэл, мэргэжлийн ёс зүй, хариуцлагатай байх чадварыг чухалчлан зарим сургуулиуд хөтөлбөрөө бүрэн шинэчилсэн. Тухайлбал, МУБИС-ийн СӨБ, ЕБС-ийн багш бэлтгэх хөтөлбөрүүд, ШУТИС болон зарим ДБСБ-ын санаачлан хэрэгжүүлж эхэлсэн хиймэл оюун ухаан, робот гэх мэт хөтөлбөрүүдийг дурдаж болох бөгөөд эдгээр нь сургалтын хөтөлбөр ба хөдөлмөрийн зах зээлийн нийцлийг хангахад чухал алхам болно гэж үзэж байна [9].

Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд дурдсанаар манай улс ажиллах хүчний олон янз байдал, хөдөлмөрийн зах зээлийн бүтцээр 141 орноос 39-д эрэмбэлэгдсэн нь чамлахааргүй үзүүлэлт юм [10]. БШУЯ-ны статистик мэдээнээс үзэхэд 2015-2016 оны дээд боловсрол эзэмшсэн төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь 50.7%, 2019 онд ажил эрхлэлт нь 79.6%, МБСБ төгсөгчдийн 71.6 хувь болж тус тус өссөн байна [11].

Мөн мэдлэгээ хэрэглэх, бүтээлчээр сэтгэх чадваруудыг үнэлэх Олон Улсын Сурагчийн Амжилтын Үнэлгээ (PISA)-нд манай улс 2022 онд анх удаагаа хамрагдаж, цаашид тогтмол оролцох болсон нь дээр дурдсан чадваруудыг үнэлж, дүгнэх, үр дүнтэй бодлого боловсруулахад хөндлөнгийн баталгаатай мэдээллийн сан, үнэлгээний сайн түршлага бий болох боломжтой болов [12].

Тулгамдаж буй асуудлууд

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд нийт хүүхдүүдийн 20,2% буюу 5 хүүхдийн нэг нь хамрагдаж чадахгүй байна, үүнд, хот суурин газрын ядуу болон шилжин суурьшсан өрхийн хүүхдүүд, хөдөөгийн малчдын хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зонхилж байна. Судалгаанаас үзэхэд цэцэрлэгийн байршил, хэвшлээс хамаарсан үйлчилгээний

чанар, хүүхдийн хөгжлийн үзүүлэлтийн ялгаатай байдал ажиглагдаж байна. **Бага, дунд боловсролын хувьд** бүлэг дүүргэлт бүс нутаг, байршлын хувьд харилцан адилгүй байна. Үүнд, шилжилт хөдөлгөөн, хот хөдөөгийн ялгаатай байдал нөлөөлж, боловсролын үйлчилгээний чанар, үр дүнд сөрөг үр дагавар авчирч байна [13]. Дэлхийн өрсөлдөх чадварын судалгаагаар бага боловсролын нэг багшид харьцах суралцагчийн тоогоор 141 орноос 110-д байгаа нь хангалттай үзүүлэлт биш юм [10]. Үндэсний хэмжээнд зохион байгуулсан суурь боловсролын чанарын үнэлгээний судалгаагаар хөдөөгийн сургуулийн сурагчдын сурлагын амжилт хотын хүүхдүүдтэй харьцуулахад 2.0-8.2 хувиар доогуур үзүүлэлттэй гарсан байна [13].

Хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, малчин, амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхдүүдийн сургуулийн гадна байх, сургууль завсардах эрсдэл өндөртэй байгаа нь залуусын бичиг үсгийн боловсролын түвшин доогуур байхад нөлөөлж байна [13].

Бага боловсролын түвшинд МХТ-ийн чадвар, дасан зохицох, зөрчилдөөнийг шийдвэрлэх, эрсдэл хүлээх, бизнес сэтгэлгээ, дэлхийн иргэний талаарх мэдлэг, ойлголт, чөлөөт ардчилсан оролцоотой байх чадварыг эзэмшүүлэхэд анхаарах; **суурь боловсролын түвшинд** мэдээллийн технологийн болон монгол ба дэлхийн иргэний чадваруудыг судлагдахуун бүрийн онцлогтойгоор сургалтын хөтөлбөрт тусгах боломжийг эрэлхийлж, үр чадваруудын тэнцвэртэй байдлыг хангахад анхаарах шаардлагатай байна. ЕБС-ийн суралцагчид хөдөлмөрийн суурь үр чадварыг эзэмших, багаар ажиллаж сурах хэрэгтэйг судалгааны үр дүн онцолжээ [14]. Түүнчлэн ЕБС-ийн сурагчдын байгалийн ухаан, математикийн бүтээлч сэтгэлгээ сул байгааг ч мөн зарим судалгааны үр дүнгүүд харуулжээ [15], [16].

Мэргэжлийн боловсролын хувьд, МБС-ын тухай хуулийн санхүүжилтийн шинэлэг зохицуулалтууд хэрэгжээгүй нь салбарын шинэчлэл, түншлэл-олон талын оролцоо, сургалтын чанар, суралцагч, төгсөгчийн мэргэшлийн үр чадварт сөргөөр нөлөөлж байна. Ажил олгогчдын зүгээс төгсөгчдөд гадаад хэлний мэдлэг, мэдээллийн технологийн хэрэглээ, бичиг баримт боловсруулах, бие даан ажиллах, багаар ажиллах, оновчтой шийдвэр гаргах зэрэг үр чадваруудыг олгох, хувь хүний хандлагыг төлөвшүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрх зүйн мэдлэг, дадал олгох шаардлагатайг онцолж байна [4].

Мэргэжлийн боловсролд дэлхийн хөгжлийн чиг хандлагатай холбоотойгоор суралцах чадвар, бүтээлч байдал, инноваци, шүүмжлэлт сэтгэлгээ, технологийн үр чадвар, ногоон үр чадвар, гадаад хэл, компьютер, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй, мэргэжлийн өндөр үр чадвар асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах чадваруудыг хичээлийн агуулгад интеграцчилах байдлаар сургалтын баримт бичгүүдэд нарийн тодорхой тусгах шаардлагатай [17].

Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн үр дүнгээс үзвэл идэвхтэй хүн амын дижитал үр чадвар 141 орноос 96-д эрэмбэлэгдсэн нь өмнөх жилээс ахисан ч сайжруулах

шаардлагатайг илтгэж байна [10]. Энэхүү үр дүн үндэсний судалгаагаар ч мөн нотлогдож байна. Тухайлбал, дижитал бичиг үсэгт тайлагдах эрэлт хэрэгцээ өндөр байхад 15-24 насны залуучуудын тал хувь нь энэхүү бичиг үсэгт тайлагдаагүй [8], багш нарын дижитал ур чадвар сул байна [4]. Мөн дэлхийн өрсөлдөх чадварын тайланд манай улс төгсөгчдийн ур чадварын үзүүлэлтээр 141 орноос 119-д, мэргэжлийн боловсролын сургалтын чанараар 141 орноос 100-д эрэмбэлэгджээ [10]. Энэ нь хэдий өмнөх жилээс ахисан ч мөн л хангалтгүй үзүүлэлт юм. Түүнчлэн “ирээдүйн ажиллах хүчний ур чадвар”-аар 141 орноос 113-т буюу өмнөх жилээс буурсан, “чадвартай ажилтан олж авах хялбар байдал”-аар 141 орноос 140-д эрэмбэлэгдсэн нь анхаарах чухал асуудал гэж харагдаж байна [10].

Хэдийгээр дээр нэрлэгдсэн чадваруудыг бодлогын баримт бичиг, сургалтын хөтөлбөрт тодорхой түвшинд тусгасан ч үндэсний түвшинд үнэлэх, баталгаажуулах ажил хангалттай сайн хийгдэхгүй байгаа нь үнэлгээний найдвартай арга хэрэгсэл, түршлага дутмаг байгаатай холбоотой байна [18].

МБСБ-ын элсэлт, түүний дотор эмэгтэй суралцагчдын тоо буурах хандлагатай болж, боловсрол-хөдөлмөрийн тогтолцоон дахь эрэлт, нийлүүлэлтийн зарчим хангагдахгүй байна [4]. Мэргэжлийн боловсрол эзэмшсэн 2 төгсөгчийн 1 нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байгаагаас үзэхэд хөдөлмөрийн зах зээлийн шингээлт багатай мэргэжлээр элсэлт авч байгаа эсэх, тухайн ажлын байранд ур чадварын зөрүү гарч байгаа эсэх, мэргэжил сонголтын алдаа байгаа эсэхийг нарийвчлан судалж, анхаарал хандуулах хэрэгтэй байна [11].

Дээд боловсрол эзэмшин нийгэмд бэлтгэгдэн гарч байгаа төгсөгчдөөс авсан судалгаагаар дадлагын ажлыг чанаржуулах, хугацааг уртасгах, дадлага хийх албан байгууллага, үйлдвэртэй оюутныг холбож өгөх саналыг хамгийн их хувьтай гаргасан байна. БШУЯ-наас дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ давхцалыг арилгах, нэгтгэн интеграцчилах бодлого баримталж байгаа хэдий ч, хөдөлмөрийн зах зээлийн тэлэлттэй уялдан цоо шинэ мэргэжлээр сургалтын хөтөлбөрүүд боловсруулж хэрэгжүүлэх сорилтууд тулгарч байна [14].

Насан туршийн боловсролын тухайд 2018 оны байдлаар үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй НТБ-ын нийт 354 төвөөс өөрийн гэсэн тусдаа байртай төв улсын хэмжээнд 4 (үүнээс Улаанбаатар хотод 3, хөдөө орон нутагт 1) байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм [13].

Түүнчлэн **насан туршийн боловсролын** асуудал зөвхөн боловсрол нөхөн олгох төдийгөөр хязгаарлагдахгүй, салбар дамнасан шинж чанарыг агуулдаг тул сургуулийн өмнөх боловсролоос эхлээд насанд хүрэгчдийн тасралтгүй боловсролын орчинг хамарсан нэгдсэн зохицуулалт, менежмент хийх бодлогын зохицуулалт хийх, институтчлах, өнөөдөр бий болсон тогтолцооны хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна [18]. Өсвөр үеийнхэн, залуучууд тунгаан бодох, төлөвлөх, шийдвэр гаргах, бусадтай холбоо

тогтоох, сэтгэл хөдлөлөө удирдах, өөртөө итгэлтэй байх, стрессийг зохицуулах, бусдыг ойлгох зэрэг харилцааны болон хорт зуршил, хүчирхийллээс сэргийлэх үр чадварт суралцах хэрэгцээтэй байгаагаа илэрхийлж байна [4] .

Шийдвэрлэх арга зам:

Дээр дурдсан асуудал, сорилтуудыг шийдвэрлэхэд дараах алхмуудыг хийх шаардлагатай байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан албан болон албан бус боловсролын сургалтын хөтөлбөрт шаардлагатай үр чадваруудыг залгамж холбоотой тусгах;
2. Бүх шатны боловсролын орчинг хамарсан бодлогын нэгдсэн зохицуулалт, менежмент хийх, институтчилах, тогтолцооны хүчин чадлыг нэмэгдүүлэх, бодлогын баримт бичгийг уялдуулах;
3. Төгсөгч, залуу ажилтнуудад шаардлагатай үр чадвараа ажлын байран дээр хөгжүүлэх боломжоор хангахад төр, сургалтын байгууллага төдийгүй хувийн хэвшил, ажил олгогч бусад оролцогч талуудын оролцоог идэвхжүүлэх;
4. Ур чадвар эзэмшилтийн ялгаатай байдлыг хот, хөдөөд багасгахын тулд багшийг чадавхжуулах, суралцахуйн орчин, нөхцлийг бүрдүүлэх, арга зүйн оновчтой шийдлийг боловсруулах, хэрэгжүүлэх;
5. Багшлахуй, суралцахуйн арга зүйд МХТ-ийн ашиглалтыг нэмэгдүүлж, иргэдэд МХТ эзэмших үр чадварыг сургууль, мэргэжил, сургалтын болон насан туршийн боловсролын төвөөр дамжуулан олгож, хүүхэд, залуучуудын дижитал үр чадварыг сайжруулах;
6. Зөөлөн үр чадваруудыг үнэлэх, хэмжээсжүүлэх баталгаатай арга хэрэгслийг боловсруулж, үндэсний түвшинд боловсролын үнэлгээнд хэрэглэх, үр дүнг бодлого боловсруулахад хэрэглэх;

Эх сурвалж:

- [1] The Organization for Economic Co-operation and Development, “*Skills for Social Progress: The Power of Social and Emotional Skills, OECD Skills Studies,*” 2015. [Online]. Available: <https://doi.org/10.1787/9789264226159-en>.
- [2] “Thematic action track 2 on Learning and skills for life work and sustainable development discussion paper,” *Transforming Education Summit*. [Online]. Available: <https://transformingeducationsummit.sdg4education2030.org/AT2DiscussionPaper>. [Accessed: 17-Jun-2022].
- [3] World Economic Forum, *The Future of Jobs Employment, Skills and Workforce Strategy for the Fourth Industrial Revolution*, 2016. [Online]. Available: http://www3.weforum.org/docs/WEF_Future_of_Jobs.pdf

- [4] Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам, Залуучуудын төлөө *Монгол улсын төр болон түншлэгч байгууллагууд, өсвөр үеийнхэн, залуучуудын хамтын ажиллагааны үнэлгээ*, 2022.
- [5] McKinsey Global Institute, Skill shift. Automation and the future of the workforce, Washington DC, 2017.
- [6] Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн, *Сургалтын хөтөлбөрт туссан чадамжийн шинжилгээ судалгааны тайлан*, 2022.
- [7] Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, *Тогтвортой хөгжлийн боловсролыг ерөнхий боловсролын сургуулийн сургалт, сургалтыг дэмжих ажиллагаанд интерацчилах арга зүй*, 2018.
- [8] Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Шинжлэх Ухаан Технологийн Сан, Боловсролын Хүрээлэн, *21 дүгээр зууны монгол суралцагчийн цогц чадамжийг боловсролын түвшнээр тогтоох нь судалгааны тайлан*, 2021.
- [9] Азийн хөгжлийн банк, Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, *Дээд боловсролын дэд салбарын судалгаа*, 2019.
- [10] K.Schwab. *The global competitiveness report*, 2019. in the World Economic Forum (Vol. 9, No. 10). 2019, December.
- [11] Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт, *Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан*, 2020.
- [12] Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, *“Боловсрол 2030” Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө*, 2019.
- [13] Боловсролын хүрээлэн, *Монгол Улсын Боловсролын суурь мэдээлэл судалгааны тайлан*. 2019.
- [14] *Монгол улсын “Тогтвортой хөгжлийн зорилго-4”-ийн хэрэгжилтийн ахиц дэвшлийн тойм үнэлгээ (2016-2021)*,
- [15] S. Gendenjamts, *The Development Of Test To Measure Higher Order Thinking Skills in Science Among Mongolian Primary School Students*, Unpublished doctoral dissertation submitted to Hiroshima University, Japan, 2020.
- [16] K. Otgonbaatar, *Examining Mathematical Creativity Among Mongolian Ninth-Grade Students Using Problem-Posing Approach*. Journal of Education and Practice, 11(27), 69-75. 2020.
- [17] А. Амаржаргал, нар Шинэ чадварын бодлого, хэрэгжилтийн судалгааны тайлан, 2016.
- [18] Азийн Хөгжлийн Банк, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, *Насан туршийн боловсролын дэд салбарын судалгааны тайлан*, 2019.

4. БАГШ, БАГШЛАХУЙ БОЛОН БАГШИЙН МЭРГЭЖИЛ

Аливаа улс орон, бүхий цаг үед багшийн асуудалд онцгой анхаарал хандуулж иржээ. ЭЗХАХБ-ын тайланд “Академик боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй суралцагчдад мэдлэг, ур чадвар, үзэл санааг дамжуулах үйл явцыг мэргэжлийн үйл ажиллагаандаа багтаасан хүнийг багш гэнэ” хэмээн тодорхойлжээ [1]. Энэхүү тодорхойлолтыг өнөөдөр эргэж харах болсон байна. Багшлахуй нь “Боловсролын зорилгыг хэрэгжүүлэх багшийн үйл ажиллагаа”, багш мэргэжил нь “Багшлахуйд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогц” юм.

Ач холбогдол. Улс орны хамгийн чухал капитал нь тухайн улсын иргэн. Иймд багш мэргэжлийн үндсэн үүрэг нь хүнээр хүн бүтээх буюу ирээдүйн иргэний бие, сэтгэл, оюуны хувьд хөгжүүлж, төлөвшүүлэхэд чиглэнэ. Иймээс багш нь хувь хүний төдийгүй, улс орны хөгжлийн дэмч болж, үүгээр багш мэргэжлийн үнэ цэн тодорхойлогддог. Мөн КОВИД-19-ийн цар тахлын үед дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд боловсролд урьд өмнө байгаагүй тасалдал үүсч, боловсролын хүртээмж, сургалтын үр дүн, сурагчдын оролцоо, тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдалд илэрч буй ноцтой өөрчлөлтөөс үүдэн багш арга барил, хандлага, мэргэжлийн ур чадварт том өөрчлөлтийг нэхэх боллоо.

Ололт амжилт. Боловсролын тухай хууль (2002), Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008), Бага, дунд боловсролын тухай хууль (2002), Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль (2009), Дээд боловсролын тухай хууль (2007), Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль (2018)-д багш бэлтгэх, багшийг хөгжүүлэх, тэдний ажлын нөхцөл, нийгмийн баталгааг хангах бодлого, эрх зүйн үндсийг бүрдүүлж ирсэн. Багшийн албан тушаалын тодорхойлолт, тэдгээрт тавигдах шаардлага, багшлах эрх олгох, багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх журам, мэргэжлийн хөгжил, цалингийн шатлал, урамшууллын талаар харилцан уялдаатай шийдвэрүүдийг гаргажээ. Өнөөдөр манайд 26 хөтөлбөрөөр 39 их, дээд сургууль жил бүр 4000-4500 оюутныг багш мэргэжлээр төгсгөж байна.

Багшийн хангалт (2020-2021 оны хичээлийн жил) [2]

| Нийт багш | СӨБ | | ЕБС | | МБС | | ДБ | |
|-----------|------|-------|-------|-------|------|------|------|------|
| | тоо | хувь | тоо | хувь | тоо | хувь | тоо | хувь |
| 2020-2021 | 8827 | 94.3% | 34073 | 99,8% | 2124 | | 7143 | |

Тулгамдаж буй асуудлууд

Боловсролын бүх түвшинд багшийн хангалтын хувь өндөр, ил хомсдол арилсан дүр зураг харагдаж байгаа ч далд хомсдол арилаагүй байна. Мөн суралцагчдын сурлагын амжилт, монгол хүний амьдралын чанар, улс орны өрсөлдөх чадвар зэрэг гаралтын үр дүнгүүдэд тулгамдсан асуудал харагдсаар байна.

Багшийн нэр хүнд, үнэлэмж, ажиллаж буй нөхцөл. Монголд, багш нар бодит ачаалал, багшид ирэх дарамт, нийгмийн өмнө хүлээх хариуцлага, өндөр үр чадвар шаардсан мэргэжлийн үйл ажиллагаандаа нийцээгүй нийгмийн статус, үнэлэмжтэй ажиллаж байна.

Баримт дурдвал:

Амьдрах нөхцөл. 1000 багш тутмын 444 нь орон сууцанд, 300 нь сууцны тусдаа байшинд (хашаа байшин), 154 нь монгол гэрт, 31 нь нийтийн байранд, 25 нь хауст, 21 нь айлд, 16 нь нийтийн байранд, 6 нь оюутны байранд, 2 нь зориулалтын бус сууцанд (орон сууцны жижүүрийн өрөө, хонгил гэх мэт) амьдарч байна. [3]

Цалин хөлс. Олон улсын багш нарын цалингийн дундаж болон өөрийн орны бусад салбарын ажиллагсдын цалингаас доогуур, инфляцийн өсөлтийг гүйцэхгүй, долларын ханшны өсөлтөөр тооцож үзэхэд 2020 онд 2014 оны цалингаас 96.5\$-оор буурсан байна. [4]

Багшид ирэх дарамт. Эцэг эх, олон нийт, удирдлагаас үзүүлэх шахалт шаардлага, мэргэжлийн үр чадварын хомсдол, бүхимдлын дор багш үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн шийдвэр гаргах үйл явцад оролцох эрх зүйн боломж хязгаарлагдмал, ажил олгогч үүргээ биелүүлээгүйн улмаас үнэлэмжгүй хөдөлмөр эрхэлж эрх ашиг нь хохирох явдал түгээмэл, тухайлбал, бүлэг дүүргэлт цэцэрлэгт 20-25, ЕБС-д 35 байхаар журамласан боловч нормоос хэтэрсэн багшийн нэмэлт ачааллыг зохицуулах шийдлийг олоогүй байна. [5]

Засаглал. Багш өөрийгөө хөгжүүлж сургалтад анхаарахаас илүүтэйгээр удирдлагатай ойлголцох, ажлын байраа хадгалахын төлөө сэтгэл зовинох нөхцөл байдал үүсжээ. *Боловсролын байгууллагын удирдлага, менежмент хэт ойрхон давтамжтай өөрчлөгдөж байгаа ба намын гишүүнчлэлээс хамааралтай байна.* [6] *Эмх замбараагүй, тохиолдлын ч гэмээр байдлаар удирдах ажилтныг сонгон томилдгийг дараах тоо баримтаас харж болно. 2018-2019 оны хичээлийн жилд цэцэрлэгийн эрхлэгчийн 25.8%, ЕБС-ын захирлын 17.4%, МСҮТ-ийн захирлын 8%, их, дээд сургуулийн захирлын 5.3% нь боловсролын салбарт ердөө 0-5 хүртэлх жил ажилласан, туршлага багатай шинэ, залуу удирдах ажилтнууд ажиллаж байгаа ажээ.* [6]

Дээр дурдсан бодит нөхцөл байдал:

- Багш мэргэжлийг үнэгүйдүүлж, багшийн хомсдол бий болох суурь нөхцөлийг бүрдүүлсэн.
- Чанаргүй элсэлт - чанаргүй багш - чанаргүй сургалтын гинжин хамаарлыг бий болгосон.
- Албан ёсны бус төлбөртэй сургалт, үйлчилгээ явуулах нөхцөлийг бүрдүүлж “сүүдрийн боловсрол” бодитойгоор бий болоход хүргэсэн зэрэг болно.

Багшийн бэлтгэл, багшийн тасралтгүй хөгжил, багшлахуй: Багш бэлтгэх хөтөлбөр болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, тогтвортой хөгжлийн зорилтууд хоорондын уялдаа сул, магадлан итгэмжлэгдээгүй хөтөлбөрөөр багш бэлтгэж байгаа нь төгсөгчдийн чанарт нөлөөлсөн гэх үндэстэй [7].

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагаа нь ихэнхдээ бодит байдлаас тасарсан, “зөвхөн сул тал дээр нь төвлөрсөн” арга барилтай, төвөөс боловсруулсан, “нэг удаагийн” байх нь элбэг, ихэнхдээ ажлын байрнаас гадуур зохион байгуулагддаг. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрч буй боловч нийлүүлэлтэд суурилсан, дээрээс доошоо чиглэсэн хандлага зонхилж, “багшийн эрэлтэд суурилсан мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хүргэх” зарчим захиргаа, менежментийн бүхий л түвшинд хөгжөөгүй байна [8].

Монгол улсад 2004 оноос чадамжид суурилсан боловсролын стандартыг нэвтрүүлж, сургуулийн тогтолцоог 10 жилээс 11 жилд, 11 жилээс 12 жилийн сургалттай болгох шилжилтийн үед багш нар шинээр чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан. ЕБС-ийн суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээ, дүнгийн шатлал 4 удаа, багш нарын ажлыг үнэлэх шалгуур, үзүүлэлтүүд 3 удаа ойр ойрхон өөрчлөгдсөн ч эдгээр асуудал өнөөдөр ч оновчтой шийдлээ бүрэн олоогүй байна. Сүүлийн 20 жилийн хугацаанд өөрчлөлт хийх тухай 22 шийдвэр баталсан бөгөөд тэр болгондоо шинэ бодлого, өөрчлөлтийг тусгасан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлжээ [9].

Монголчууд үр хүүхдээ өөрийн биеэр үлгэрлэн зааж сургах (бихеовиризм), бие даасан үйлийг нь дэмжиж бодит орчинд хөгжүүлэх (конструктивизм), танин мэдэхүйн өвөрмөц арга хэрэгслээр оюун ухааныг хөгжүүлэх (когнитивизм) хүний хөгжлийн тулгуур үзэл дээр төлөвшиж ирсэн үнэт өв уламжлалаас бид хол хөндий байна. Үүнтэй холбогдуулан ЮНЕСКО-оос “Монгол улсын боловсролын тогтолцоо монгол улсыг олон улсын тавцанд интеграцчлан хөгжүүлж, ирээдүй хойч үеийн иргэндээ даяарчлалын боловсрол олгох нь өөрсдийн өвөрмөц өв уламжлалыг хүндлэн дээдэлдэг иргэн болгон хүмүүжүүлэхэд хэр нийцтэй байгааг бодож үзэх шаардлагатай болж байна” гэж дүгнэжээ [10].

“Сурагчид дамжуулсан мэдлэгийг хүлээн авагчид бус харин шүүмжлэлт хэрэглэгчид, илүү шинэ шинэлэг багшлахуй, суралцахуйн хандлага шаардаж буй мэдлэг бүтээгчид” гэдгийг боловсролын бүх түвшний багш, удирдах ажилтнууд сайн ойлгож итгэл үнэмшил болгох нь чухал. Энэхүү итгэл үнэмшил багш хүн мэдлэгт төвлөрөхөөс гадна сурагчдад хэрхэн сурахыг нь зааж, сурах чадварыг нь хөгжүүлэх, сэтгэл хөдлөл, зан үйлд илүү төвлөрөх үзэл баримтлал болох учиртай.

Аймаг нийслэлийн БСГ-ын бүтцэд захиргааны чиг үүрэг давамгайлж, боловсролын нэгж байгууллагад боловсролын шинэчлэлийг мөн чанараар нь хүргэх мэргэжлийн чадамж эрс суларснаар сургууль өөрчлөлтөөс хоцорч, багш тасралтгүй хөгжих боломжоо алдаж байна. *Аймаг, нийслэлийн БСГ-ын 217 үндсэн ажилтны 186 (85.7%) нь захиргааны чиг үүрэг, 31 (14.3%) нь мэргэжлийн чиг үүрэг гүйцэтгэдэг байна* [11].

Шийдвэрлэх арга зам

Боловсролыг жам ёсны хөгжлийн замд оруулж, хүн ёсыг дээдэлсэн эрдэм боловсролтой монгол иргэнийг бүтээхийн тулд юу хийх ёстой вэ?

- Багш бэлтгэх сургалтын байгууллагад чадварлаг сурагчдыг элсүүлэх бодлогыг сайжруулан хэрэгжүүлэх, багш мэргэжлийн нэр хүндийг өсгөж, цалин хөлс, нийгмийн баталгааг хангах үйлдээ холбоо бүхий, нэгдсэн бодлогыг интеграцчлах;
- “Сургууль бол мэргэжилтнүүд уулзан цуглаж, хамтран суралцдаг талбар” гэдэг талаас нь харж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үзэл баримтлалыг өөрчлөх, Монгол улсын бүхий л холбогдох удирдах ажилтнуудыг дээрх зарчмыг танилцуулах сургалтад хамруулах, сургуулийн менежментээр дамжуулах;
- Боловсролын байгууллагын удирдлагын томилгоог улс төрөөс хамааралгүй болгох, удирдлагын шийдвэрт багш, олон нийт, сургуулийн зөвлөлийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Боловсролын бүх түвшинд ялангуяа хөдөө орон нутгийн сургуульд чанартай, сайн багш нарыг ажилд авах, тэднийг тогтвортой ажиллуулахад эергээр нөлөөлж буй хүчин зүйлсийг олж илрүүлэх үүднээс батлагдсан бодлого, арга хэмжээнүүдийг эргэн харж, сайжруулах;
- Орон нутаг дахь боловсролын мэргэжлийн удирдлагын бие даасан тогтолцооны тасалдал, хомсдлыг арилгаж сургуулийн шинэчлэл, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих;
- Багшийг мэргэжлийн чиг үүрэгт хамааралгүй ажилд оролцуулах, хууль тогтоомжид заагаагүй тайлан, мэдээлэл шаардах, хяналт шалгалт хийх, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үүрэг хүлээлгэх зэргийг хориглох замаар багшийн ажлын ачааллыг тооцоолж, оновчлох;
- Багшийн ёс зүйн асуудлыг сургууль, орон нутагт нь бүрэн утгаар нь шилжүүлэх, багшлах эрх олгох, мэргэжлийн зэрэг олгох, цуцлах, багшийн ажлыг үнэлж дүгнэх, журмын шалгуур үзүүлэлтийг оновчлох арга хэмжээ авах.

Эх сурвалж:

- [1] OECD, Боловсролын системийн үзүүлэлтүүд тайлан, 2004.
- [2] БШУЯ., Статистик мэдээ, 2020-2021., Эх сурвалж: <https://www.meds.gov.mn>.
- [3] БШУЯ, Боловсролын Хүрээлэн, Ерөнхий боловсролын сургуулийн багшийн нийгмийн асуудал судалгаа, 2021.
- [4] БСШУСЯ, Боловсролын Хүрээлэн, ЮНЕСКО-гийн Үндэсний комисс., Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан, 2019.
- [5] Боловсролын хүрээлэн, Багшийн статустай холбогдох эрх зүйн баримт бичигт хийсэн дүн шинжилгээ, 2020.

- [6] ЮНЕСКО. Боловсролын сектор, Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ, 2019.
- [7] Энхтүвшин.Ж., Цогбадрах.С. Дээд боловсрол ISSN: 2707-6202 сэтгүүл. № 02., Бага, дунд боловсролын цөм хөтөлбөр, багш бэлтгэх хөтөлбөрийн үялдаа холбоог сайжруулах асуудалд, 2020.
- [8] ЮНЕСКО. Боловсролын сектор, Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ, 2019.
- [9] БСШУСЯ, Боловсролын Хүрээлэн, ЮНЕСКО-гийн Үндэсний комисс., Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан, 2019.
- [10] ЮНЕСКО. Боловсролын сектор. Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ, 2019.
- [11] БШУЯ-ны, БДБ-13, 2021-2022 оны хичээлийн жилийн тайлан.

5. БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ

Улс орны эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд төдийгүй хүний хөгжил, иргэд, өрхийн амьжиргаанд боловсролын үүрэг өндрөөр үнэлэгдэж, татвар төлөгчдөөс цуглуулсан хөрөнгийн багагүй хэсгийг төр боловсролын үйлчилгээнд зарцуулдаг учраас энэхүү хөрөнгөөр хийж бүтээхээр зорьсон зорилтоо биелүүлж чадаж байгаа эсэх нь чухал юм.

Бодлогын баримт бичигт боловсролын зорилго, агуулга цогц байдлаар тодорхойлогдох хэдий ч энэ нь оновчтой санхүүжилтийн тогтолцоо, эх үүсвэрийн дэмжлэггүй бол хэрэгжих боломжгүй. Иймээс боловсролын зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд боловсролын санхүүжилтийн бодлого чиглэдэг байна. Боловсролын санхүүжилт нь дан ганц төрөөс боловсролыг санхүүжүүлэх асуудлыг багтаадаггүй. Боловсролыг санхүүжүүлэхэд өрх гэр, орон нутаг, хувийн хэвшил (ААН, ИНБ), олон улсын хандивлагч байгууллага оролцоо, хамтын хүчин чармайлт чухал ач холбогдолтой.

Боловсролын зорилтыг хангахад санхүүжилтийн механизм нь “Тэгш байдлыг хангах”, “Сонгох боломж, эрх чөлөөг хангах”, “Үр ашиг, үр дүнг хангах”, “Бүтээмж, эдийн засгийн өсөлтийг хангах” гэсэн үндсэн үүрэгтэй байна [1].

Энэ хүрээнд гарсан томоохон ололт амжилтыг тоймлон танилцуулбал:

- ✓ Монгол улсын боловсролын талаар баримтлах бодлогод боловсролыг нийгмийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх [2,3], үзэл баримтлалыг баталгаажуулсан бөгөөд ЗГ-ын тогтоолоор батлагдсан боловсролыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөгөөр боловсролын зорилт, авах арга хэмжээ, санхүүжилт илүү тодорхой болсон [4].
- ✓ Боловсролын салбарын төрийн санхүүжилт 2022 онд ДНБ-ий 4.4%, улсын төсвийн нийт зарлагын 12.8%-ийг эзлэхээр байна. Үүнээс харахад НҮБ-ын гишүүн орны хувьд үүрэг амлалтаа биелүүлэхээр байна [5].
- ✓ Тэгш хүртээмжтэй, үр ашигтай байх зарчмыг баримтлан санхүүжилтийг нийлүүлэлтэд суурилсан хэлбэрээр, сургуулийн хэв шинж, байршил, хүүхдийн тооноос хамаарч тооцох бодлогыг хэрэгжүүлж, хувьсах зардлын норматив, нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тооцох аргачлалыг шинэчилсэн [5].
- ✓ COVID-19 цар тахлын үед цахим, танхим, холимог сургалтын хэлбэр, 5/9 зарчимд тулгуурласан менежментийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан санхүүжилтийн чиглүүлгийг хийж амжилттай хэрэгжүүлсэн [6].
- ✓ Олон улсын хэмжээнд боловсролын бодлогыг хүний үндсэн эрх гэж авч үздэг учир боловсрол эзэмших эрхийг хүндэтгэх, биелүүлэх, хамгаалах нь төрийн чиг үүргийн нэг болдог. Эдгээр чиг үүргээс гадна төр хүний боловсрол эзэмших эрхийг батлан даагч болох ёстой [7]-г чухалчилсан.
- ✓ Боловсролын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хувьд салбарын хэмжээнд бодлого, хэрэгжилт, эрдэм шинжилгээ-судалгааны байгууллагын үндсэн бүтцэд өөрчлөлт оруулж уялдааг хангаж өргөжүүлсэн.

Тулгамдаж буй асуудлууд

Өнөөдөр аливаа улс орны хөгжлийг эдийн засгийн үзүүлэлтээс илүү хүний хөгжлөөр нь хэмжиж байна. Боловсролын салбарын санхүүжилтэд тухайн улс орны эдийн засгийн хүчин чадал, хүн ам зүйн бүтэц, үрт хугацааны өсөлт, техник технологийн үсрэнгүй хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийгмийн байдал зэрэг хүчин зүйлс хүчтэй нөлөөлөл үзүүлдэг [5]. Тухайлбал;

- Боловсрол нь хүний хөгжлийн суурь бөгөөд тасралтгүй, насан туршийн хөгжлийг дэмжих төдийгүй мэдлэг, чадвар, зөв хандлага, цогц чадамжтай, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах иргэнийг бэлтгэхэд чиглэгдэж буй нь цаашид боловсролын санхүүжилтийг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй.
- Нийгмийн хөгжлийн индексийг тодорхойлогч суурь хүчин зүйлс болох хүнс тэжээлийн хомсдол, нялхсын эндэгдэл, ядуурлын түвшинд амьдарч буй иргэд, бичиг үсэг тайлагдалт, нийгмийн ялгаатай хэрэгцээ бүхий иргэдийн эзлэх хувь зэрэг нь боловсролын санхүүжилтийн тэгш, хүртээмжтэй байх шаардлагыг тодорхойлоход нөлөөлж байна.
- Техник, технологийн хөгжил нь боловсрол эзэмшүүлэх үйл явцад хувьсал авч ирэхийн зэрэгцээ нийгэм, эдийн засгийн хөгжилд ч хүчтэй нөлөөлж байна. Энэ нь улмаар хөдөлмөрийн зах зээлд хэрэгцээтэй үр чадвар, ажлын байрны хэрэгцээг богино хугацаанд эрс өөрчлөх нөлөөтэй байна. Иймд боловсролын тогтолцоо, санхүүжилт нь энэ хувьсан өөрчлөгдөх хүчин зүйлд хариу өгөх уян хатан чадамжтай, үр ашигтай байх хөгжлийн шаардлага тавигдаж байна.

Эдгээртэй холбоотойгоор боловсролын шинэчлэлийг дэмжихэд санхүүгийн ямар шинэчлэл хийх хэрэгтэй байгааг (гол асуудал) тодруулав. Үүнд:

А. Боловсролын санхүүжилтийг бэхжүүлэх, солонгоруулах

- Боловсролын санхүүжилтийн ДНБ-тэй уялдах хувь хэмжээг хууль тогтоомжид тусгаагүй, боловсролын тухай хуульд улсын төсвийн 20-оос доошгүй хувийг боловсролын төсөвт зарцуулна гэсэн заалт хүчингүй болсон зэргээс эдийн засгийн мөчлөгөөс хамаарч төсвийн алдагдалтай үед салбарын санхүүжилт танагдах, буурах эрсдэл бодитой хэвээр байна.

Б. Боловсролын санхүүжилтийн тэгш, хүртээмжтэй байдлыг сайжруулах

- Хувьсах зардлын шинэчлэл ЕБС, СӨБ-ын түвшинд хэрэгжиж байна. Тэгш, хүртээмжтэй байдлыг мэргэжлийн боловсрол, дээд боловсрол, насан туршийн суралцахуйн түвшинд мөн авч үзэх шаардлагатай. Цаашид боловсролын тэгш бус байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг арилгахад санхүүжилтийн хүртээмжтэй, үр дүнтэй байдлыг чиглүүлж, тасралтгүй сайжруулах хэрэгцээ байна.

В. Боловсролын санхүүжилтийн үр ашигтай байдлыг сайжруулах

- Төсвийн хуваарилалт, гүйцэтгэлийн зарцуулалт, түүний үр дүн болон үр ашгийг тооцоолох аргачлал, түүний таниулах ажлууд тогтолцооны хувьд бүрэн төлөвшиж,

бэхжээгүй байна. Тухайлбал, санхүүжилтийн үр ашиг, шилжин суурьшилт ба боловсролын үр нөлөөг тооцоолох судалгааны ажлууд дутмаг [9, 10, 11].

- Төсөв хуваарилах, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог хангах заалт орсон хэдий ч оролцоог хэрхэн хангах талаар зохицуулалт сул байна. Энэ нь зарцуулалтын хяналт сул байх үндэслэл болж байна.

Шийдвэрлэх арга зам

Улс орон бүр иргэдийнхээ хөгжлийг дэмжиж, сурч боловсрох эрхийг нь хангахын тулд боловсролын салбарын бодлого, төлөвлөлтийг 2-3 жилээр бус 10-20 жилийн хугацаагаар алсыг харж, үр дүнг нь тооцож төлөвлөж байх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улс Ковид-19 цар тахлын үед цахим, танхим, холимог сургалтын хэлбэр, 5/9 зарчимд тулгуурласан менежментийг хэрэгжүүлж, ололт амжилт, бэрхшээл, сургамжуудыг тодруулан ажиллаж байна [8]. Үүнээс үүдэлтэй боловсролын тогтолцооны хувирган өөрчлөлтийг санхүүжүүлэх боломж, хамтын оролцоо, шийдлийг тодруулах нь чухал болоод байна. Бид дараах арга зам, боломжуудыг тодруулж байна. Үүнд:

А. Боловсролын санхүүжилтийг бэхжүүлэх, солонгоруулах

1. Төрийн санхүүжилтийн хууль эрх зүйн орчныг сайжруулж ДНБ, улсын төсвөөс боловсролд оногдох хувийг баталгаажуулах;
2. Тэргүүлэх чиглэлийн хүрээнд дотоодын санхүүжилтийг бэхжүүлэх, солонгоруулах – салбар хоорондын тэнцэлд анхаарч, уялдааг сайжруулах;
3. Үндэсний болон олон улсын хэмжээнд боловсролын салбарт төр, орон нутаг, эцэг эх, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх.

Б. Боловсролын санхүүжилтийн тэгш, хүртээмжтэй байдлыг сайжруулах

1. Боловсролын түвшин бүрд хүрэх үр дүн, зорилттой уялдуулан санхүүжилтийг тэгш, хүртээмжтэй байдлаар хуваарилах (НТБ-ыг анхаарах);
2. Санхүүжилт, төсвийг тэгш, хүртээмжтэй байдлаар хуваарилах аргачлалыг (өсөн нэмэгдүүлэх итгэлцүүр) түгээн дэлгэрүүлэх, ил тод байдлыг хангах;
3. Санхүүжилтийн шийдвэр гаргах (сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнахад) үйл явцад багш, ажилтан зэрэг талуудын оролцоог сайжруулах.

В. Боловсролын санхүүжилтийн үр ашигтай байдлыг сайжруулах

1. Төсвийн хуваарилалт болон санхүүжилтийн үр дүн, үр ашгийг тооцоолох аргачлалыг боловсруулах, түгээн дэлгэрүүлэх, ил тод байдлыг хангах;
2. Гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, урамшуулах санхүүжилтийг тооцоолох аргачлалыг боловсруулах, тогтмол давтамжтайгаар хэрэгжүүлэх;
3. Уур амьсгалын өөрчлөлт болон дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлээс шалтгаалсан шилжин суурьшилт боловсролын санхүүжилтэд үзүүлэх нөлөөллийг

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

- тооцох, зохих үр дүнтэй хариу арга хэмжээ авах;
4. Үрэлгэн зардлыг бууруулах, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлэх, хариуцлагажуулах (Тухайлбал; Багшийн хөгжлийн сургалтуудад, гүйцэтгэл, үр дүнд суурилж зарцуулалт хийх г.м.)

“Боловсрол бол хүмүүсийн төдийгүй улс орны орлогын ялгаанд нөлөөлөх гол хүчин зүйл, хамгийн чухал хөрөнгө оруулалт бөгөөд боловсролд хөрөнгө оруулснаар хувь хүн төдийгүй улс орны ирээдүйд олох орлогыг нэмэгдүүлнэ” (Gary Becker, 1964)

Эх сурвалж:

- [1] Ross, Levacic (1999). *Needs-based resource allocation in education: via formula funding of schools*
- [2] МУИХ. (2020). *Урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”*
- [3] МУИХ. (2015). *Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024.*
- [4] МУЗГ. (2020) *Монгол Улсын боловсролын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө*
- [5] БШУЯ, Санхүү, хөрөнгө оруулалтын газар,
- [6] БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, IRIM. (2020). *Онцгой байдлын үеийн теле хичээл, түүний үр дүн, тохиромжтой байдал* судалгааны тайлан
- [7] ЮНЕСКО. (2010) *Rethinking Education. Towards a global common goods.,*
- [8] ЮНЕСКО. (2020). *Залуучууд, насанд хүрэгчдийн суралцахуйг дэмжих нээлттэй, зайны сургалт.* КОВИД-19-ийн эсрэг ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын хариу арга хэмжээ Боловсролын онцлох асуудлууд Асуудал
- [9] ЮНЕСКО, (2019). *Шилжилт хөдөлгөөн, дүрвэлт ба боловсрол* Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан
- [10] Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (2018). *Хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа 2018*
- [11] Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (2018). *Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа 2018*

СЭДЭВЧИЛСЭН 5 ЧИГЛЭЛ ТУС БҮРЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ

Холимог сургалтын арга нь давуу талтай. Онолын мэдлэгээ авчихаад практик тал нь 70 хувь байвал багшид ч хэрэгтэй. Сурагчидтайгаа илүү тулж ажиллана. Ингэвэл ажиллахад хөнгөн болох байх. Түвшнээс хамаараад өөр байвал зүгээр. Хувилбартай байх.

Хүүхэд залуучуудын төлөөлөл

1. ДИЖИТАЛ СУРАЛЦАХУЙ БА ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ

Төрөөс хэрэгжүүлж буй бодлого, туршлага

Бодлогын түвшинд

- Боловсролын салбарт цахим шилжилтийг хэрэгжүүлэх үүднээс бодлого, хэрэгжилт, дэд бүтцийг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий нэгдмэл тогтолцоог бүрдүүлж эхэллээ. Үүнд: БШУЯ-д “Цахим бодлого, статистикийн хэлтэс”, БСҮХ-д “Өгөгдөл боловсруулалт, цахим судалгаа хөгжүүлэлтийн судалгааны сектор”, БЕГ-т “Цахим шилжилт, нэгдсэн статистикийн газар”, БШУЯ-ны дэргэд “Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ байгуулснаас гадна Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт мэдээллийн технологи, сүлжээ, систем хариуцсан мэргэжилтний орон тоог шинээр бий болгон хүний нөөцийг үе шаттайгаар чадавхжуулж эхэллээ.
- Боловсролын салбарын мэдээллийн систем, сургалтын цахим контент, удирдлагын систем, мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ болон боловсролын дата төвийн хяналт, тогтвортой ажиллагааг хангахын тулд:
 - Боловсролын салбарын бүх түвшинд боловсролын удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлж, боловсролын үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж байна.
 - Багш, суралцагчид зориулсан орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсэн үндэсний цахим сургалтын MEDLE.MN платформыг хөгжүүлж, хэрэглэж эхэлсэн.
 - Боловсролын нэгдсэн сүлжээг үүсгэж, салбарын мэдээллийн урсгал, контентын хэрэглээний ачааллыг даан ажиллах чадамжтай мэдээллийн технологийн дэд бүтэц бүрдээд байна. Төрийн болон орон нутгийн өмчийн бүх ЕБС-ийг боловсролын нэгдсэн сүлжээнд холбосон. Энэхүү сүлжээний нийт хурд нь 4.75 Gbps байна.
 - Төрийн өмчийн зургаан их сургуулийн суралцагчид харьяалал харгалзахгүйгээр хичээл сонгох, боловсролын зарим үйлчилгээг авах боломжтой болсон.

Хувийн хэвшлийн сайн туршлагауд:

- Төр, хувийн хэвшлийн түншлэл бэхжсэн. Тухайлбал, үүрэн телефоны үндэсний дөрвөн оператор нийгмийн хариуцлагын хүрээнд суралцагч, багш нарт цахим сургалтын системийн орчинд дата унахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.
- Цахим сургалтын системийг хөгжүүлэхэд манлайлж, энэ чиглэлээр өрсөлдөөн байна. Тухайлбал. “Их нүүдэл” сургалтын цахим системийг зарим ЕБС-ууд ашиглаж байна.

“Хувьсаж буй боловсрол” үндэсний хэлэлцүүлгийн үеэр гарсан зарим санаачилгууд:

1. Цахим боловсролын бодлого, эрх зүйн зохицуулалт бий болгох

- **Судлаачид** цахим сургалт, суралцахуйн талаар ойлголтоо нэг болгох, цахим боловсролын эрх зүйн орчныг бүрдүүлэх, цахим шилжилтийн бодлого зохицуулалтыг боловсруулах (цахим шилжилтийн урт, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай санхүүжилт, нөөцийг дайчлах замаар дэмжих), цахим сургалтаар эзэмшсэн боловсролын үр дүнг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх механизмыг бий болгох санаачилга гаргав.
- **Бизнес эрхлэгчдийн төлөөллийн** зүгээс цахим сургалтын үр дүнгээ бодитойгоор тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх саналыг дэвшүүлэв.
- **Судлаачдын хяналт ба засаглалыг бэхжүүлэх тал дээр** бүх түвшний боловсролын салбарын мэдээллийн системийг (EMIS) бүрэн хөгжүүлснээр салбарын бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хэрэглэж хэвших гэсэн санал гарсан. Харин иргэний нийгмийн байгууллага боловсролын салбар ихэнх төсвөө технологийн компанид зарцуулж байгаа учир эрсдлээ тооцох шаардлагатай гэсэн.

2. Багшийн цахим (дижитал) үр чадварыг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх

- **Судлаачид** багш нарын цахим үр чадвар, заах арга зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж чадавхжуулах, мөн багш нар хамтран суралцах, ажиллах, мэдлэг, үр чадвараа харилцан хуваалцах хамтын ажлын нэгдлийг дэмжих саналыг гаргав.
- **Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн төлөөлөл багш** өөрийгөө хөгжүүлэх, контент бүтээх үр чадварт суралцах боломжийг бий болгох санал гаргав.

3. Технологид суурилсан боловсролын нээлттэй нөөцийг хөгжүүлэх (түвшинчлэл, сонголт, ялгаатай байдлыг харгалзсан) суралцахуй агуулга

- **Иргэний нийгмийн байгууллага** сургалтын хөтөлбөрийн агуулгыг танхимд судлах, цахимаар судлах гэдгээр ялгаж тодорхойлох, хосолсон сургалтын хөтөлбөрийг сурагчдын хэрэгцээ, ялгаатай байдалд тулгуурлан боловсруулах санаачилга гаргав.

- **Хүүхэд залуучуудын төлөөлөл** боловсролын бүх түвшний суралцагчид өөрт тохирсон цахим сургалтын материалыг үздэг, өөрсдийгөө үнэлдэг үндэсний нээлттэй санг бүрдээлэх саналыг гаргав.
- **Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн төлөөлөл** сургалтын хөтөлбөрийн агуулгад код бичих агуулгыг оруулах, сургалтын хөтөлбөр боловсруулахад хөндлөнгийн оролцоог нэмэгдүүлэх санаачилгыг дэвшүүлэв.
- **Бизнес эрхлэгчдийн төлөөллийн** зүгээс улсын төсвөөр боловсруулсан контент, хувийн хэвшлийн боловсруулсан контентуудыг нэгдсэн нэг системд оруулж нээлттэй байх санал гаргав.

Дээрх нэгдсэн платформ дээр зөвхөн төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа сургалтын материал биш бизнесийн байгууллагын тодорхой шалгуур хангасан сургалтын хөтөлбөр, материалыг оруулж хүүхдүүдэд нэгдсэн байдлаар хүрэх боломжийг нээж өгч болох юм. Энэ нь төр, бизнесийн байгууллага хоорондын уялдаа холбоог гаргах төдийгүй бизнесийн байгууллагуудын маркетингийн зардлыг хэмнэх томоохон ажил болно.

Бизнес эрхлэгчдийн төлөөлөл

5. Хүртээмжтэй, уян хатан байдлыг хангахуйц тоног төхөөрөмж, сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх

- **Иргэний нийгмийн байгууллага** зорилтот бүлэгт чиглэсэн тусгай тоног төхөөрөмжийг сайжруулах, нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн платформтой байх хэрэгцээтэй гэж тэмдэглэв.
- **Бизнес эрхлэгчдийн төлөөллийн** зүгээс дэд бүтцийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төхөөрөмжөөр хангах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр нэмэлт арга хэмжээ авах хэрэгтэй байна.
- **Хүүхэд, залуучуудын** зүгээс суралцагчдыг сурах бичгүүдийн цахим сантай планшетаар хангах, Монгол Улсад платформыг хөгжүүлэхдээ фэйсбүүкээс татгалзан, улсаас хяналттай өөрсдийн системийг бүтээх. Жишээ нь: монгол чат, монгол фэйсбүүк хөгжүүлэх хамтран хийх боломжтой. Мөн төлбөргүй хүүхэд хичээлээ хийх боломжийг бүрдүүлсэн төвүүд, мэдээллийн технологийн кабинетыг дүүрэг, хороонд байгуулах санал гаргав.

Монгол Улсын платформыг хөгжүүлэхдээ фэйсбүүкээс татгалзаад, улсаас хяналттай өөрсдийн системийг бүтээх. Жишээ нь: монгол чат, монгол фэйсбүүк. Нөхцөл нь ч уян хатан байх юм. Энэ тохиолдолд эцэг эх төдийгүй нийтээрээ хяналт тавих, зөвхөн хүүхэд ч биш бүх насны хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хамгаалах давуу талтай

Хүүхэд, залуучуудын төлөөлөл

6. Аюулгүй цахим орчин бүрдүүлэх

- **Бизнес эрхлэгчдийн төлөөллийн** зүгээс цахим орчны зохистой хэрэглээнд хүүхдийг багаас нь төлөвшүүлэх, сургалтын хөтөлбөрт энэ чадварыг тусгах санаа гаргав.
- **Сэтгүүлч хэвлэл мэдээллийн төлөөлөл** цахим орчны соёлыг бий болгох, эрсдлийг бууруулахын тулд эцэг эхийн хүүхэддээ нөлөөлөх чадварыг бий болгох, хүүхдийг хянах аппликейшн боловсруулах, гэр бүл болон сургуулийн орчинд сургалтын платформоос бусад facebook, Instagram гэх мэт хүүхдүүдийн их ашигладаг платформын хэрэглээг цагаар хязгаарлах, хүүхэд олон нийтэд зориулсан цахим орчинд өөрийн аюулгүй байдлыг хангах мэдлэг мэдээллийг боловсруулж, бодит кейс дээр суурилсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх, сурталчлах ажлыг эрчимжүүлэх санаачилгыг гаргав.
- **Иргэний нийгмийн байгууллага** кибер аюулгүйн байдлаар мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, эцэг эхчүүд хянах цахим систем бий болгох, цахим орчны аюулгүй байдлын талаар мэдээллээ нууцлах, хамгаалах талын өргөн мэдлэг, ойлголтыг бүх нийтэд эзэмшүүлэх, цахим сургалтын бодлого хөтөлбөр нь хүүхдийн эрхэд нийцэж байгаа эсэх, ялгаатай байдалд мэдрэг байгаа эсэх зэрэгт үнэлгээ хийхэд оролцуулах санал гаргав.
- **Хүүхэд, залуучуудын зүгээс** цахим гэмт хэргээс сэргийлэхийн тулд хүүхэд эцэг эх, гэр бүл, багш, нийгмийн ажилтантайгаа асуудлаа чөлөөтэй ярьж зөвлөгөө авдаг болохыг тэмдэглэв.

2. ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ

Хэрэгжүүлж буй бодлого, туршлага

- 2016 онд Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиуд батлагдаж суралцагчийг аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, үл хайхрах байдал, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зохицуулалт тодорхой болсон.
- ЕБС-ийн сургалтын орчны аюулгүй байдлын стандарт, дотуур байрны орчин, үйлчилгээнд тавигдах шаардлага, сургалт хүмүүжлийн эрүүл ахуйн шаардлага, СӨБ-ийн сургалтын орчны стандартыг 2018, 2019 онд тус тус гаргасан.
- ХБХ-ийн сурч боловсрох эрхийг хангах зохицуулалтыг элсэн суралцах, суралцах үеийн дэмжлэг, нийгэмд идэвхтэй оролцоотой байх талаас нь дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалт хийгдсэн.
- Сургууль дээр сурагчдад эрүүл, шим тэжээлт хоол хүнсээр үйлчлэхийн тулд нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг нэмэгдүүлэн “Үдийн цай” хөтөлбөрийг 2022 онд “Үдийн хоол” болгон өргөжүүлсэн.
- Иргэний нийгмийн байгууллагуудаас аюулгүй сургууль, хүүхдийн эрх оролцоог

хангах чиглэлээр олон нийтийн оролцоог хангах, асуудлыг тодорхойлох зэргээр манлайлан ажилладаг.

- КОВИД-19 цар тахлын үед үндэсний хэмжээнд 16 телевизийн суваг болон econtent.edu.mn сайтаар дамжуулан нийт 5284 теле хичээлийг бэлтгэн суралцагчдад хүргэсний зэрэгцээ алслагдсан сум, багийн сургуулийн болон боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд хэвлэмэл болон тохируулгат материал боловсруулан хүргэж, зайнаас суралцах боломж олгосон.
- Цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг 5:9 зарчмаар танхим болон зайнаас хичээллүүлсэн нь олон улсад сайн туршлага хэмээн үнэлэгдсэн. Эдүгээ сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, суралцахуйг дэмжих сургалт үйл ажиллагааг хэрэгжүүлэх, сургуульд эргэн ирэх, дасан зохицох цогц төлөвлөгөөг гурван үе шаттай төлөвлөн хэрэгжүүлж байна.
- Орон нутаг, сургууль, багш нар өөрийн онцлог, нөөц, боломждоо тулгуурлан зайн сургалт болон хичээл сурлагын хоцрогдлыг арилгах туршлагууд бий болгосон. Мөн сургуульдаа эргэн ирж суралцахад сурагчид бие биедээ тусалж, ярилцаж байсан.

Манай хичээл багш нар яг сургууль дээр орж байгаа юм шиг онлайн өрөөнүүдэд хуваагдан хичээл зохион байгуулж, ганцаарчлан зөвлөгөөг их өгдөг байсан.

Сурагчдын төлөөлөл

Хэлэлцүүлгээс гарсан санаачилга

1. КОВИД 19 боловсролын тасалдлыг бүрэн даван туулахад

1. Оношилгоо, үнэлгээнд тургуурлаж суралцахуйн хоцрогдлыг нөхөх, сургалтын хосолсон хэлбэр, холбогдох нөөцийг тасралтгүй хөгжүүлэх

- *Судлаачдын зүгээс суралцагчдын суралцахуйн алдагдлыг тодорхойлох, хэмжих, сургалтын ахиц дэвшлийг илрүүлэх болон нэгтгэн дүгнэх зорилгоор суралцагчийн үнэлгээний хэрэгслийг боловсруулах ашиглах, илүү нээлттэй, уян хатан үнэлгээ, баталгаажуулалтын бүтэц, тогтолцоог хөгжүүлэх хэрэгтэй гэж үзсэн.*
- *Хүүхэд, залуучуудын төлөөллөөс сургалтын чанарыг ахиулах, тасралтгүй суралцах цахим болон танхимын хосолсон сургалтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, суралцагчид бие биенээсээ суралцах платформ бий болгох, сургалтын иж бүрэн хэрэглэгдэхүүнээр хангах шаардлагатай талаар санал гаргав.*
- *Иргэний нийгэм байгууллагаас суралцахуйн хоцрогдлыг нөхөхөд сургуулийн түвшинд үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгох, бага боловсролын хоцрогдлыг нөхөж, арилгахад нэн тэргүүнд анхаарахыг сануулсан.*

Сурах дургүй хүүхэд гэж байдаггүй. Багшийн бид нарт хандах хандлага, хичээл сонирхолгүй байх зэргээс болоод бид хичээлдээ дургүй болдог.

Сурагчдын төлөөлөл

2. Боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай хүргэх цогц төлөвлөгөөг хөгжүүлэх

- *Иргэний нийгэм, олон улсын байгууллага:* Цар тахлын үед болон дараа нь боловсролыг том зураглалаар харж чадаагүй учраас үнэлгээ болон шаардлагатай арга хэмжээг хийж чадаагүй. Энэ нь бэлэн байдлын төлөвлөгөөтэй байх хэрэгцээг үүсгэж байна.

II. Боловсролыг хувирган өөрчлөхөд

1. Үндэсний хэмжээнд сургуулийн менежментийг хувиргах (сургууль, сургалтын байгууллагын бүхлээр ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх)

- *Бүх оролцогч талууд* сургуулийн бие даасан байдлыг дэмжих, сургуулийн асуудлыг шийдвэрлэхэд суралцагч, багш, ажилтнууд, эцэг эх, олон нийт, байгууллага, орон нутгийн оролцоо, хамтын ажиллагааны чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх, нөөцийг үр ашигтай ашиглах замаар суралцахуйн орчныг хувирган өөрчлөх тал дээр санал нэгдэв.

Хэрэглэгчид суралцагчдын саналыг хүлээн авч, шийдвэрлүүлэхэд анхаардаг, шийдвэрлүүлэх тал дээр ажилладаг, тогтвортой үйл ажиллагаа бүхий бүлгүүдийг, нэгжүүдийг дүүргийн, нийслэлийн, аймгийн, сумын хэмжээнд байгуулах. Энэ нь хүүхдүүд, залуучууд бидний дуу хоолойг сонсох, санал санаачилгыг дэмжих нэг суваг болно гэж үзэж байна.

Залуусын төлөөлөл

- Түүнчлэн технологид суурилсан сургууль, ногоон сургууль гэхчлэн суралцахуйн олон хэлбэрийг бий болгох, шинэлэг, орчин үеийн хандлагаас суралцах хэрэгтэйг дурдав.
- Боловсролын үйлчилгээнээс гадна үлдэж буй суралцагчдад чиглэсэн арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх, сургуулийн онцлогт нийцүүлэн уян хатан хөтөлбөр боловсруулах шаардлагатайг онцолсон.

Үе тэнгийн дээрэлхэлтийг үгүй хиймээр байна. Цахим орчинд, бас хөвгүүд бие биенээ их дээрэлхдэг, ядуу айлын хүүхдийг илүү их дээрэлхдэг. Хэл яриа, бие эрхтний онцлогоор ялгаварладаг, дээрэлхдэг.

Сурагчдын төлөөлөл

- *Хэвлэл мэдээллийн төлөөллийн зүгээс* боловсролын чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчийг бэлдэх, олон нийтийн оролцоог бүхлээр нь хангахад хувь нэмэр оруулах, сургуулийн менежментийн туршлагауудыг тогтмол сурталчлах боломжтой.
- *Хүүхэд, залуучуудын төлөөлөл* сургууль, сургалтын байгууллагын ажилчид (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хоол зүйч, эмч, бусад)-ын мэргэжлийн үр чадвар, хандлага, хамтын ажиллагааг өргөжүүлэх, дээшлүүлэх хэрэгтэй гэж үзсэн.
- *Иргэний нийгмийн байгууллагууд* төрийн байгууллагатай хамтарч ажиллах, ачааллыг хуваарилж ажиллах, тэгш хүртээмжтэй эрүүл аюулгүй сургууль бий болгоход хувь нэмэр болох нөөц боломжоор дэмжих боломжтой гэж байна.

2. Боловсролын тогтолцоонд тэгш хамруулсан зарчмыг баримтлах

- *Судлаачид, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагууд:* Боловсролыг улс төрөөс ангид байлгах, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах, тэгш хүртээмжтэй, чанартай боловсролын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур аргачлалыг тусгайлан боловсруулж, боловсролын албан ёсны мэдээллийн санд тэдгээртэй холбоотой өгөгдөл мэдээллийг цуглуулж, нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх түвшинд талуудын оролцоог хангах хэрэгцээтэй байна гэж үзсэн.
- *Хүүхэд, залуучуудын төлөөлөл:* Багшийн мэргэжил, арга зүй, ёс зүйн ойлголт хандлагад анхаарлаа хандуулах, багш бэлтгэх хөтөлбөрт эрс өөрчлөлт хийх хэрэгцээг онцолсон.
- *Бүх оролцогч талууд:* Материаллаг болон сэтгэл зүйн орчны хувьд суралцагчдад суралцах, хөгжих таатай, ээлтэй орчныг цогцоор бүрдүүлэх, ялангуяа суралцагчдын нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үйлчилгээнд анхаарал хандуулах; эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх санал дээр нэгдэв.
- *Иргэний нийгмийн байгууллагууд:* Боловсролын төсөв, төлөвлөгөөг ялгаварлан гадуурхалгүй, тэгш боломжоор хангасан, зорилтот стратегиар боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэйг онцоллоо.
- *Хүүхэд, залуучуудын төлөөллийн зүгээс* шийдвэр гаргалтад суралцагчдын дуу хоолой, санал бодлыг тусгах, тэднийг чанартай мэдээллийн эх үүсвэрээр хангах санал гаргав.

Багш, эцэг эх, асран хамгаалагчид, суралцагчид хэн нь ч эгэх хариуцлагатай байх чадварыг эзэмшвэл сурлагын хоцрогдлыг арилгах, сургуулийг тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй болгоход чиглэсэн бодлого амьдрал дээр хэрэгжих боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Залуучууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

3. АЖИЛ, АМЬДРАЛ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ СУРАЛЦАХУЙ БА УР ЧАДВАР

Төрөөс хэрэгжүүлж буй бодлого, туршлага

- 2014-2016 онд шинэчлэн боловсруулагдсан СӨБ, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх, харилцах, бие даан суралцах, өөрийгөө хөгжүүлэх, багаар болон хамтарч ажиллах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээллийн технологийн хэрэглээний чадварыг тодорхой тусган хөгжүүлж байна.
- Тогтвортой хөгжлийн боловсролын зорилт, арга зүй, цогц чадамжийг ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тусгаснаар сурагчид тодорхой хичээлийг судалсны үр дүнд тогтвортой хөгжлийн үзэл санаа шингэсэн мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх боломж, нөхцөл бүрджээ.
- БСҮХ 21 дүгээр зууны Монгол суралцагчийн “Тоонон” загвар суралцагчийн цогц чадамжийн хүрээг тодорхойлж, “21 дүгээр зууны монгол суралцагчийн цогц чадамж”-ийг боловсролын түвшинд тохируулан боловсруулав. Энэхүү цогц чадамжийн хүрээ нь олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдөж буй ажил хөдөлмөр, тогтвортой хөгжлийн төлөөх чадваруудтай нийцэл сайтай боловсруулагджээ.
- Мэдлэгээ хэрэглэх, бүтээлчээр сэтгэх чадваруудыг үнэлэх Олон Улсын Сурагчийн Амжилтын Үнэлгээ (PISA)-нд манай улс 2022 онд анх удаагаа хамрагдаж, цаашид тогтмол оролцох болсон нь дээр дурдсан чадваруудыг үнэлж, дүгнэх, үр дүнтэй бодлого боловсруулахад хөндлөнгийн баталгаатай мэдээллийн сан, үнэлгээний сайн туршлага бий болох боломжтой болов.
- Ковидын үеийн нөхцөлд 2021-2022 оны хичээлийн жилээс ЕБС-иудад орон тооны сэтгэл зүйчид ажиллаж эхэлснээр сурагчдад сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, нийгэмшил-сэтгэл хөдлөлийн чадварыг нь дэмжих бодит боломж бүрдэв.
- Монгол улс ногоон ур чадварыг хөгжүүлэх талаар ногоон хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх төлөвлөгөө (2016-2030) баталж, ногоон, эко сургууль хөдөлгөөн, техникийн болон мэргэжлийн боловсрол ба сургалтыг ногоон болгоход чиглэсэн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр, НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийн чиглэлийн их, дээд сургуулиудад ногоон ур чадварыг хөгжүүлэх “Ногоон эдийн засаг” хичээлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- АХБ-ны санхүүжилтээр БШУЯ-наас 2012-2019 онд хэрэгжүүлсэн “Дээд боловсролын шинэчлэл төсөл”-ийн хүрээнд сургалтын хөтөлбөрийг шинэчлэхдээ суралцагчдад шинийг эрэлхийлэх, асуудал шийдвэрлэх, системтэйгээр төлөвлөх, багаар ажиллах, бичгийн болон цахимаар харилцах

чадвар, гадаад хэл, мэргэжлийн ёс зүй, хариуцлагатай байх зэрэг чадварыг чухалчлан зарим их сургуулиуд хөтөлбөрөө бүрэн шинэчилсэн.

- ШУТИС болон зарим ДБСБ-ын санаачлан хэрэгжүүлж эхэлсэн хиймэл оюун ухаан, робот зэрэг хөтөлбөрүүд сургалтын хөтөлбөр ба хөдөлмөрийн зах зээлийн нийцлийг хангахад чухал алхам болно гэж үзэж байна.
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олох мэдээллийн төвийг байгуулан, хүүхэд, залуучууд, иргэд үр чадвараа хөгжүүлэхтэй холбоотой, мөн мэргэжил сонголттой холбоотой мэдээллийг авах боломжтой болсон.
- Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилгаар цөлжилтийн эсрэг ойн санг нэмэгдүүлэх, мод тарих хөдөлгөөнийг эрчимжүүлэх, урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх эрх орчин бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн эхлүүлэн бүх нийтийн оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэнээр, иргэдийн тогтвортой хөгжлийн мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлж байна.

Бизнес эрхлэгч, хувийн хэвшлийн сайн туршлагууд:

- **“Томуо” ХХК** нь залуучуудын ажил, хөдөлмөр эрхлэх үр чадварыг дэмжих, чадавхжуулах зорилгоор салбарын шилдэг багш, менторуудтай биечлэн болон цахимаар уулзах, суралцах боломжийг платформоор дамжуулан олгож байна.
- **“Шимт боловсрол” ХХК** бага боловсролын сурагчдын технологийн хэрэглээний мэдлэг, чадвар эзэмшүүлэх зорилготой сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг боловсруулж бага сургууль, цэцэрлэгүүдэд амжилттай хэрэгжүүлж байна.
- **“Гэрэгэ систем”** мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын энэ чиглэлийн үр чадварыг хөгжүүлж, төсөл дээр ажиллуулах, бүтээлээ бусдад танилцуулахад нь дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах байдлаар их, дээд сургуулийн үүргийг хуваалцаж байна.
- **“Шимт боловсрол” ХХК** бага боловсролын сурагчдад 21 дүгээр зууны зорилтот чадамж, STEAM боловсрол эзэмшүүлэх сургалт, контентийн үйлчилгээг 2019 оноос үзүүлж байна.
- **Номын худалдаа эрхэлдэг компаниуд** иргэдийн зөөлөн үр чадварыг хөгжүүлэх номнуудыг хөнгөлөлттэй үнээр худалдаж, түгээж байна.

... Бусдыг ойлгох чадвар дутмаг байна. Бие биенээ гомдоох, цаашлаад хүүхдүүд сэтгэл гутралд орох явдал их байна. Нэгнийгээ сэтгэл зүйн хүнд байдалд оруулдаг ингэснээр хүүхэд хөгжих, суралцах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

... Байгал орчны яам, боловсролын яамтай хамтраад хүүхдүүдийн ногоон үр чадварыг сайжруулах чиглэлээр ажиллаасай, сургалтын агуулгад оруулаасай.

Сурагчдын төлөөлөл

“Хувьсаж буй боловсрол” үндэсний хэлэлцүүлгийн үеэр гарсан зарим санаачилгууд:

1. Чухалчилж буй үр чадваруудыг хөгжүүлэх талаар:

- Залуучуудын төлөөлөл мэдээллийн хэрэгсэл, цахим платформоор дамжуулж залуучууд, насанд хүрэгчдэд зориулж нарийн мэргэжлийн талаарх мэдээлэл өгөх, мэдээлэлд шүүлтүүртэй хандах, насан туршдаа суралцахуйг нь дэмжих нөлөөллийн контент, таниулах үйл ажиллагааг зохион байгуулах боломжтойг илэрхийлэв.
- Бизнес эрхлэгчид чухалчилж буй үр чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн аудио болон цахим контент, подкаст, сургалтын хэрэглэгдэхүүнийг сурлагчид болон насанд хүрэгчдэд зориулж боловсруулж, түгээхэд бэлэн байна. Бизнес эрхлэгчид төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх үр чадварыг нь хөгжүүлж, мэргэшүүлэхэд зориулсан хамтын сан үүсгэхэд хөрөнгө гаргах боломжтой.

... Оюутан, залуучуудыг цалинтай дадлага хийж, үр чадвараа хөгжүүлэх боломжоор хангах хэрэгтэй байна. Цалин хөлс нь мөнгөн бус урамшуулал байж болно. Залуучууд практик нөхцөлд үр чадвараа хөгжүүлэх боломж олгосны хариуд бүтээгдэхүүнийг нь цахим болон энтертайнмент хэлбэрээр сурталчилж өгдөг байж болно...

.... Ажил олгогчид ажилд авахдаа ажлын туршлага заах бус үр чадвараар нь тохирсон ажил олгох боломжийг нээлттэй байлгах хэрэгтэй...

Залуучуудын төлөөлөл

2. Үр чадваруудыг хөгжүүлэхэд хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлэх талаар:

... Сургууль төгссөн хүүхдийг 1 жил дадлагажуулж байж сая нэг ажилтан болгож байна. Нэг ажилтныг бэлдэхэд ойролцоогоор 15 сая төгрөг зарцуулж байна. Хувийн байгууллага бүр 2 сая төгрөг гаргаад сан үүсгээд, төгсөгчдийг мэргэшсэн, үр чадвартай ажилтан болгоход зарцуулъя.

Бизнес эрхлэгчдийн төлөөлөл

- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн төлөөлөл боловсролын чиглэлээр мэргэшсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, боловсролын зорилгод хөгжүүлэхээр тусгасан үр чадварыг нийтлэлийн бодлогодоо тусгаж, олон нийтэд тогтмол сурталчлан таниулахад хувь нэмэр оруулахад бэлэн байна.
- ОУ-ын байгууллага болон хэвлэл мэдээллийн төлөөлөл боловсролын зорилгыг бүх нийтийн зорилго болгох, чадварлаг иргэнтэй нийгмийг цогцлоохын тулд төр, хувийн хэвшил, эцэг эх, олон нийтийн оролцоог бүхлээр нь хангахад бодитой хувь нэмэр оруулах боломжтойгоо илэрхийлэв.

... Боловсролыг бүх нийтийн зорилго болгох, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэггүй төр, хувийн хэвшлийн байгууллагууд ч өөрийн үйл ажиллагаандаа боловсролын зорилгод тусгасан чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх тогтолцоо, соёлыг бүрдүүлэх, түүнийг урт хугацаандаа тасралтгүй, тууштай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулъя.

Олон улсын байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл

КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй сурлагын хоцрогдлыг нөхөх, хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд ажиллаж амьдрахад чухал ач холбогдолтой мета-танин мэдэхүй (*thinking about thinking*), суралцахуйд суралцахуй (*learning to learn*), сэтгэл хөдлөлөө удирдах (*emotional regulation*), аливаа зүйлд зорилго тавьж (*goal orientation*), тууштай байх (*perseverance*), бусдыг ойлгох (*empathy*) зэрэг чадваруудыг сургалтын үйл ажиллагаанд нэмэж тусган хөгжүүлэх шаардлагатай байна.

Судлаач, сурагч, бизнес эрхлэгч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл

3. Чухалчилж буй ур чадваруудыг үнэлэх талаар:

- Бизнес эрхлэгчдийн зүгээс элсэлтийн болон төгсөлтийн үнэлгээний шалгуурт ажил олгогчдын саналыг тусгаж, ур чадварын үнэлгээг хамтран зохион байгуулах боломжтой.
- Бизнес эрхлэгчдийн зүгээс оюутан, төгсөгчийн хаана ямар дадлага хийсэн, ямар сургалтад суусан, ямар чадварыг эзэмшсэн зэрэг мэдээлэл нэгдсэн санд бүртгэгддэг, баталгааждаг, ажил олгогч шаардлагынхаа дагуу тэндээс ажилтнаа хайх, сонгох боломж олгох нэгдсэн платформыг төрийн байгууллагуудтай хамтран хийх боломжтой.

4. БАГШ, БАГШЛАХУЙ БА БАГШ МЭРГЭЖИЛ

... Боловсролын системийн үнэлгээг анхаарах, агуулгын мэдлэгийг үнэлэх гэхээс илүү нийгэмшихүйн чадвар, бүтээлчээр сэтгэх, хамтран ажиллах зэрэг зөөлөн үр чадвар, хандлагыг үнэлэх нь чухал байна.

Судлаач, бизнес эрхлэгчдийн төлөөлөл

Сурах арга барилд суралцсан багш л боловсролыг хувирган өөрчилнө.

Төрөөс хэрэгжүүлж буй бодлого, туршлага

- 2019 оноос ЕБС-ийн багшийн үйл ажиллагааг өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр үнэлдэг болсон. Ерөнхий боловсролын сургуулийн чанарыг сайжруулах өөрийн үнэлгээнд суурилсан менежментийг хөгжүүлэх ажил эрчимжсэн.
- 2020 онд “Чадварлаг багш” хөтөлбөрийг тодорхойлсноор багшийн тасралтгүй хөгжил, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх, цаг үеийн хэрэгцээтэй үр чадварыг эзэмшүүлэхтэй холбоотой бодлогын шийдлийн үндэс гарсан.
- Ерөнхий боловсролын багшийн стандартыг шинэчлэн сайжруулах ажил эхэлж байна.
- Ерөнхий боловсролын багшийн МХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлага, мөн багшийг чадваржуулах үйл ажиллагааны чиглэл тодорхой болсон нь зайн сургалтын нөхцөлийг бүрдүүлсэн төдийгүй багшийн МХТ-ийн үр чадварыг хөгжүүлэх хэрэгцээг тодорхой болгосон.
- ЕБ-ийн сургууль болон багшийг ажлын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлсэн ба сургууль, багшийн тасралтгүй хөгжлийг хангах, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах, хүүхэд бүрийн боловсрох, хөгжих эрхийг хангах нөхцөлийг сайжруулсан.
- Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай хэрэглэгдэхүүнтэй холбоотой зардлыг өмнө нь багш цалингаасаа гаргадаг байсныг улсын төсвөөс гаргадаг байх зохицуулалт тодорхой болсон.
- Цэцэрлэг, ЕБС-ийн багш эрүүл мэндийн үйлчилгээ, шинжилгээнд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлсэн.
- Багш, багшлахуйн өнөөгийн нөхцөл байдлыг илрүүлэх судалгааны нэгдсэн систем бүрдүүлэх ажлыг эхлүүлсэн.

Нийгмийн бусад салбарын дэмжлэг, оролцооны тухайд:

- Багшлахуйг дэмжсэн цахим контент боловсруулахад өрсөлдөж, санаачлагатай байна.
- Багшийн ажлыг хөнгөвчилсөн сургалтын үйл ажиллагааны цахим удирдлагын системийг хөгжүүлэхэд идэвхтэй манлайлж, энэ чиглэлээр өрсөлдөөн нэмэгдсэн.

- Боловсролын үйлчилгээг нэгдсэн платформоор хийх шийдэл гаргаж байна. Тухайлбал, бүх түвшний боловсролын байгууллагын элсэлттэй холбоотой мэдээллийн цахим экспо ажиллаж эхэлсэн.
- Багшийг дэмжсэн төр, хувийн хэвшлийн түншлэл бэхжиж байна. Тухайлбал, үүрэн телефоны үндэсний дөрвөн оператор нийгмийн хариуцлагын хүрээнд суралцагч, багш нарт цахим сургалтын системийн орчинд дата унахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.
- Сайн багшийн түршлага, ололтуудаар инновацын сан бүрдүүлэхэд иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлүүд ажилласан. Багш нар харилцан түршлага солилцох нээлттэй санг бүрдүүлж байна.
- Хүүхэд, эцэг эх, багш нартай боловсролын судлаачид, мэргэжилтнүүд бусад төлөөллөөс цахим хэлэлцүүлэг хийж, цар тахлын үед хүүхдийн хөгжлийг гэр бүлийн нөхцөлд дэмжих талаар харилцах түршлага солилцох ажил идэвхижсэн.
- Үе хоорондын манлайлал болон багшийн зөөлөн үр чадварыг хөгжүүлэхэд аж ахуйн нэгжүүд сургалтын модуль боловсруулан хэрэглээнд нэвтрүүлж байна.

Хэлэлцүүлгийн үеэр гарсан зарим санаачилгууд:

1. Багшийн дүр төрх, ажил үүрэг, шийдвэр гаргалтын түвшин дэх оролцооны хувиргалт

- Суралцагчийн бие бялдар, сэтгэл зүрх, оюун ухааны хөгжлийг зөв чиглүүлэх багшийн хувийн зан чанар, зөөлөн үр чадварыг;

Соёлын биет болон биет бус өвийг тээгч, хамгаалагчийн хувьд багш хүн үндэсний үнэт зүйлээ уламжлуулан түгээн дэлгэрүүлэх, харин бусдын соёлд хүндэтгэлтэй хандах учиртай. Тэгвэл монгол үндэстэнд эртнээс уламжилж ирсэн эх дэлхийгээ хайрлан хамгаалах үзэл, дадлыг суралцагчдадаа эзэмшүүлэх нь монгол багшийн томоос том үүрэг байх ёстой.

Судлаачдын төлөөлөл. 2022.06.16

- Багшийн үндсэн үүргийг дагаж үүсэх ачаалал болон үндсэн үүрэгт хамаарахгүй ажил хөдөлмөрийг гүйцэтгэхтэй холбоотой үүсэх ачааллыг;
- Багшид ёс зүйн асуудлыг багшийн мэргэжийн холбоо, сургууль, орон нутагт шилжүүлэхийг;
- Олон нийтийн сүлжээнд байрлуулах багшийн талаарх мэдээлэлд хүний эрхийн үүднээс хандах эрхзүйн зохицуулалтыг;
- Хөдөлмөр эрхлэх орчин өөрчлөгдөж буйтай холбогдуулан ажиллах боловсон хүчний эзэмшсэн чадвар, ажлын байранд тавигдах шаардлага хоёрын зөрүүг багасгах;
- Боловсролын аливаа түвшний шийдвэр гаргалтад багшийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг;

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

2. Багш бэлтгэх болон багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцооны хувиргалт

Багш бэлтгэх их, дээд сургуулиуд үйлчилгээний чанарын шаардлага хангах ижил стандарттай байх;

Эхлээд багш бэлддэг сургуулиа хувиргачих, түүний дараа бусдыг нь ярих хэрэгтэй байна.

**Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл,
2022.06.22**

- Багшийн стандарт нь багш бэлтгэх хөтөлбөртөө тодорхой тусгагдаж, хэрэгжилтийн явцад илрэн гардаг механизмтай байх;

Багш хүн хүүхдүүдийн хүмүүжлийн асуудал ч бай, сурлагын хоцрогдол ч бай ... өөрөөсөө шалтгааныг хайн учрыг олж, алдаагаа засдаг байвал “сайн багш” болно.

Залуучуудын төлөөлөл, 2022.06.22

- Багш бэлтгэх хөтөлбөрийг суралцагчийн дүр төрх, сургалтын хөтөлбөр, бодит амьдралтай уялдуулахыг;
- Боловсролын салбар дахь багш, ажилтны жендэрийн зохистой харьцааг багш бэлтгэх сургалтаас эхлүүлэн мөрдөх;
- Багш бэлтгэх сургалтын байгууллагад чадварлаг сурагчдыг элсүүлэх бодлогыг;
- Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих мэргэжлийн бие даасан тогтолцоог;
- Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн төв нь “сургууль” болохыг;
- Орон нутгийн сургалтын байгууллагад чадвартай, сайн багшийг ажилд авах, тэднийг тогтвортой ажиллуулах хүчин зүйлсийг;

3. Багшийн амьдралын чанарыг сайжруулах хувиргалт

- Багшийн амьдрах нөхцөлийг тодорхойлж, амьдралын чанарт эергээр нөлөөлөх төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг;

Амьдрах нөхцөлөө сайжруулж чадаагүй багш ахуйн асуудлаасаа болоод суралцагчийн хөгжлийн талаар бүрэн бодож, ажиллаж чадна гэдэгт сайн итгэлгүй байна.

Сурагчдын төлөөлөл, 2022.06.24

- Багшийн ажиллах нөхцөл сайжруулахын тулд цалин хөлс, сэтгэл зүйн үйлчилгээ, боловсролын засаглалыг;
- Нийгмийн бусад салбараас багшид тухайлсан дэмжлэг үзүүлэх санаачлага өрнүүлэхийг;

5. БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ

Төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа

- Боловсролын салбарын санхүүжилт 2022 онд ДНБ-ний 4.4%, улсын төсвийн нийт зарлагын 12.8%-ийг эзэлж байгаа бөгөөд НҮБ-ын гишүүн орны хувьд үүрэг амлалтаа биелүүлж байна.
- Сургуулийн байршил, дэд бүтцийн онцлогт тулгуурласан хөрөнгө оруулалт хийх шийдэл гарч байна.
- Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд барилга байгууламжийг шинээр барьж байна. Тухайлбал; Цэцэрлэг, ЕБС-ийн хүүхдийн хувь нь шинээр баригдсан цэцэрлэг, сургуульд хамрагдаж байна.
- ДБ-ын санхүүгийн дэмжлэгтэй бага боловсролын сургалтын чанарыг сайжруулах зорилгоор 5 удаагийн төсөлт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Сумын сургуулийн бага боловсролын сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн.
- Сургуулийн хагас бие даасан санхүүгийн системийг бүрдүүлэх эхлэл тавигдсан.
- Нэг сурагчид ногдох хувьсах зардлын норм нормативыг шинэчилсэн. Сургуулийн байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамааруулан тооцдог болсон.
- Оюутнуудын хөдөлмөр эрхлэх, амьжиргааны зардлаа санхүүжүүлэх, хөдөлмөрийн харилцаа, соёлд суралцах, ажил, хөдөлмөрт бэлтгэгдэх, эзэмшиж буй мэргэжлээрээ дадлагажих, түршлагажих, мэргэших, төгсөөд ажилтай болох нийгмийн боломжийг өргөжүүлэх Засгийн газрын 2016 оны 178 дугаар тогтоолоор “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөрийг 2020 он хүртэл амжилттай хэрэгжүүлэв.
- Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд “Оюутны санаачилгыг дэмжих өрсөлдөөнт тэтгэлэг” олгосон.
- Монгол Улсын Засгийн Газрын “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд 1 сая төгрөгийн тэтгэлэгтэй сургалтын боломжоор залуусыг хангаж байгаа нь тэдний суурь хийгээд мэргэжлийн боловсрол эзэмших, насанд түршдаа суралцах боломжийг нь дэмжиж байна.
- Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2020 онд нийт 4753 оюутан зээлд хамрагдсан.
- Засгийн Газрын 2021 оны 264 дүгээр тогтоолын дагуу өвлийн амралтаараа орон нутагруу явсан, ирсэн замын зардал (500 км болон түүнээс дээш байршилтай)-ыг олгож байна.

Хэлэлцүүлгийн үеэр гарсан зарим санаачилгууд:

1. *Боловсролын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд олон талын оролцоог хангах, санхүүжилтэд инновацийг нэвтрүүлэх, хяналт бий болгох*
 - *Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл:* Сургалтын байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

- Боловсролын бонд гаргаж хөрөнгө босгох, хамтарсан сан байгуулах хэрэгтэй байна.
2. *Боловсролын чанарыг сайжруулахын тулд багшийн хөгжилд зориулсан бусад талын санхүүжилтийн санал санаачилгыг нэмэгдүүлэх*
- *Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл:* Багшийн эзэмшсэн судлагдахууны мэдлэг болон заах арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж, нөөцийн хангамж, сурлагын амжилтын үнэлгээний найдвартай бөгөөд тогтвортой тогтолцоог бэхжүүлэх зэрэг чиглэлүүдэд цаашид ихээхэн хөрөнгө оруулах шаардлагатай.
 - *Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл:* Олон сургуулийн барилгад засвар хийх шаардлагатайн дээр эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг хангахгүй байна.

Багшийг техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр тогтмол хангах хэрэгтэй.

Сурагчдын төлөөлөл

3. *Үр дүнд суурилсан боловсролын санхүүжилтийг хөгжүүлэх*
- *Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл:* Нэгж зардлын тооцоолол хийх зэргээр илүү өргөн цар хүрээтэй, үр ашиг талаас нь дорвитой судалж тооцоолол гаргах хэрэгтэй байна.
 - Сургалтын хэрэглэгдэхүүний хомсдлоос гадна сургалтын орчныг сайжруулахад чиглэсэн зардал хязгаарлагдмал байна.
 - Төрийн санхүүжилтийн хууль эрх зүйн орчныг сайжруулж ДНБ, улсын төсвөөс боловсролд оногдох хувийг баталгаажуулах

Сүүдрийн боловсролд төр зохицуулалт хийх шаардлагатай байна. (төлбөртэй давтлага, өдөр өнжүүлэх гэх мэт)

Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

4. *Аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагаас боловсролд хөрөнгө оруулахтай холбоотой төрөөс үзүүлэх хөшүүрэг, дэмжлэгийг нэмэгдүүлэх, хамтран ажиллах*
- *Аж ахуй нэгж, байгууллагын төлөөлөл:* Боловсролд хөрөнгө оруулалт хийх, үйлчилгээ үзүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, татвараас хөнгөлөх, чөлөөлөх

AIR MARKET FOUNDING орлогынхоо тодорхой хувийг боловсролын салбарт зарцуулдаг жишгийг нийтэд тогтоох хэрэгтэй байна.

Аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл

5. Боловсролын тэгш байдлыг хангахуйц санхүүжилтийн бодлого төлөвлөлтийг сайжруулах

- Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл: Монгол Улсын боловсролын тогтолцоог боловсронгуй болгоход тэгш хүртээмжтэй байдлыг хангах, боловсролын чанар ба суралцахуйн үр дүнг сайжруулах, менежментийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх гэсэн өргөн хүрээтэй үйл ажиллагаа шаардлагатай байна.

“ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ” МОНГОЛ УЛСЫН САНААЧИЛГА

ОРШИЛ

1. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеришийн ивээл дор зохион байгуулагдах “Хувьсаж буй боловсрол” дээд хэмжээний уулзалтыг угтан Монгол улсын Боловсрол, Шинжлэх ухааны яамнаас НҮБ-ын суурийн төлөөлөгчийн газар, ЮНИСЕФ, болон бусад төрөлжсөн байгууллагуудын тусламжтайгаар үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг хэд хэдэн үе шаттайгаар хүүхэд, залуучууд, багш, судлаачид, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид, хэвлэл мэдээллийн болон үндэсний, орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөл бид 2022 оны 6 сарын 16-аас 07 сарын 01 хүртэл хугацаанд зохион байгуулж, 07 сарын 05-нд нэгдсэн хэлэлцүүлэг Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа.
2. Нэгдсэн хэлэлцүүлгийн өмнө хийсэн салбар хэлэлцүүлгүүдийн үр дүн юуны өмнө залуучууд, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн оролцсон хэлэлцүүлгийн үр дүн нь өнөөдрийн нэгдсэн хэлэлцүүлэгт чухал ач холбогдолтой болсныг онцолж байна.
 - Хэлэлцүүлгийн явцад гарсан ерөнхий санал, дүгнэлтийг нэгтгэн авч үзвэл: Монгол Улсын Засгийн газар боловсролын талаар дэлхий нийтийн өмнө хүлээсэн үүрэг амлалтаа чанар, үр дүнтэй хэрэгжүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргаж, зарим ахиц амжилтад хүрснийг бид тэмдэглэж байна. Тухайлбал, Боловсролын салбарын санхүүжилт 2022 онд ДНБ-ний 4.4%, улсын төсвийн нийт зарлагын 12.8%-ийг эзэлж байгаа бөгөөд НҮБ-ын гишүүн орны хувьд үүрэг амлалтаа биелүүлж байна.
 - КОВИД-19 цар тахлын үеийн хөл хорио нь суралцагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж ганцаардах, уйтгарлах, бухимдалтай болох, сурлагаар хоцрогдохоос айх зэрэг сөрөг үр дагавар үүсэхэд хүргэсэн ба харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлд гарч буй асуудлууд нь цаашид удаан үргэлжилбэл тэдний бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүй болоод бие хүний хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.
 - КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй сурлагын хоцрогдлыг нөхөх, хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд ажиллаж амьдрахад чухал ач холбогдолтой мета-

танин мэдэхүй (thinking about thinking), суралцахуйд суралцахуй (learning to learn), сэтгэл хөдлөлөө удирдах (emotional regulation), аливаа зүйлд зорилго тавьж (goal orientation), тууштай байх (perseverance), бусдыг ойлгох (empathy) зэрэг чадварыг сургалтын үйл ажиллагаанд тусган хөгжүүлэх шаардлагатай байна (хувьсан өөрчлөгдөж буй нийгмийг таних, дасан зохицох, байгаль хийгээд хүмүүнд ээлтэйгээр хувирган өөрчлөх чадвар).

- Монгол Улсад боловсролын хамран сургалт өндөр байгаа боловч хүүхэд бүр өөрт тохирсон чанартай боловсролын үйлчилгээг зохих түвшинд авч чадахгүй байна. Газар зүйн байршил, хэл соёлын ялгаа, хөгжлийн бэрхшээл, үндэсний цөөнх, нийгэм эдийн засгийн ялгаа, жендэр, шилжилт хөдөлгөөн, дижитал хуваагдал зэрэг нь боловсролын бүх түвшинд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ авахад нөлөөлж байна.
- Боловсролыг бүх нийтийн зорилго болгох, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэггүй төр, хувийн хэвшлийн байгууллагууд ч өөрийн үйл ажиллагаандаа боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх тогтолцоо, соёлыг бүрдүүлэх, түүнийг урт хугацаандаа тасралтгүй, тууштай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах хүсэл зоригтой байна.
- Монгол Улсын боловсролын салбар дахь тэгш бус байдал, багшийн чанар, нэр хүнд, үнэлэмж, төгсөгчдийн үр чадвар, төсөв, санхүүгийн хүртээмж сул байна.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮЛЭХ САНААЧИЛГА

Боловсролыг өөрчлөн цэгцлэх, хувирган өөрчлөх талаар бид нэгдсэн ойлголт, хэтийн чиглэлтэй болох зүг рүү явцгааж байна. Боловсролыг өөрчлөн цэгцлэх гэдэг бол ганц хоёр том асуудлыг сонгон авч шийдэх тухай биш, боловсролын салбарын хоцрогдлыг арилгах, засах, сайжруулах тухай асуудал биш гэдгийг ойлгож авлаа. Харин боловсролыг өөрчлөн цэгцлэх асуудал бол боловсролын зорилгыг өөрчилж, суралцахуй гэж юу болох, яаж сурах тухай асуудал болж байна. Суралцагч нэг бүрд мэдлэг, үр чадвар, амьдралд эрхэмлэж явах зүйл (value)-ийг эзэмшүүлэх чадвартай боловсролын цоо шинэ системийг бий болгох шинэ бодлого, хандлага, арга барил, засаглалын системийг олон улсын нийгэмлэгийн тусламжтай өөрийн орны нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах ёстой болж байна.

Боловсролыг улс төрөөс ангид байлгах, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах, тэгш хүртээмжтэй, чанартай боловсролын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур аргачлалыг тусгайлан боловсруулж, боловсролын албан ёсны мэдээллийн санд тэдгээртэй холбоотой өгөгдөл мэдээллийг цуглуулж, нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх түвшинд талуудын оролцоог хангах хэрэгцээ байна.

Бүх талын оролцоо, хамтын ажиллагаа, түншлэл дор сурлагын хоцрогдлыг арилгах, боловсролыг хувирган өөрчлөхийг эрмэлзэж, дараах тэргүүлэх чиглэлийг хэлэлцэн тохирлоо.

Нэг. КОВИД-19 цар тахлын дараа сургуулийг бүрэн нээсэн үр дүнгээ бататгаж, хүүхэд бүрийг боловсролд хамруулах

1. Оношилгоо, үнэлгээний үр дүн, суралцагч бүрийн онцлог, ялгаатай байдалд суурилан сургалтын агуулга, чадварын хоцрогдлыг нөхөх, холбогдох нөөцийг тасралтгүй хөгжүүлэх;
2. Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулж, тэдний онцлог, сурах хэв маягт нийцүүлэн суралцах үйлийг дэмжих, хүртээмжтэй орчин бүрдүүлэхэд бүх талын оролцоо, түншлэлийг идэвхжүүлэн хувь хүний онцлогт нийцсэн боловсролын үйлчилгээ үзүүлэх;
3. Боловсролын системийг сэргээх, боловсролын зорилгуудад хүрэх ажлуудын эрэмбэ дараалал тогтоож, инновацыг нэвтрүүлж, үсрэлт хийж чадваас боловсролын системийг эмхлэн цэгцэлж, өөрчлөн хувиргаж чадах болно гэдэг итгэл үнэмшил төрж байна.

Хоёр. Боловсрол, боловсролын тогтолцоог хувиргах

Ур чадвартай, нийгмийн баталгаагаар хангагдсан багш

4. Боловсролыг өөрчлөн цэгцлэх асуудал багшийн мэргэжлийг өөрчлөн шинэчлэхгүйгээр хэрэгжихгүй. Багш хичээл заахаас бие даан суралцах үйл ажиллагааг дэмждэг, чиглүүлдэг болох;
5. Багшийн ажил үүрэг, хөдөлмөр эрхлэх орчны өөрчлөлтөд нийцүүлэн багшийн стандартыг шинэчлэх, багш бэлтгэх сургуульд чадварлаг сурагчдыг элсүүлэх тусгайлсан бодлого баримтлан хэрэгжүүлэх;
6. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих тогтолцоог хөгжүүлэхэд талуудын идэвхтэй хамтын ажиллагаа, оролцоог дэмжих, багшийг ажлын байран дээрээ хөгжих боломжоор хангах (дижитал ур чадвар, контент бүтээх ур чадварт суралцах Мэргэжилтнүүд сургууль дээр нь багштай хамтарч ажилладаг байх тогтолцоо);
7. Багшийн нэр хүнд, үнэлэмж, амьдралын чанарыг сайжруулахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, багшийг нийгмийн тэргүүлэх мэргэжилтэн гэж үзэж тусгайлан дэмжлэг үзүүлэх санаачилга өрнүүлэх;

Ажил, амьдрал, тогтвортой хөгжлийн төлөөх суралцахуй ба ур чадвар

8. Суралцагчдад мэдлэгээ хэрэглэх, амьдралд хэрэгцээтэй мэдлэг, ур чадвар, өөрчлөгдөж байгаа ажлын байрны ур чадвар, тогтвортой хөгжлийн ур чадварыг олгоход онцгой анхаарч ажиллах;
9. Хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд ажиллаж, амьдрахад шаардагдах мета-танин мэдэхүй, суралцахуйд суралцахуй, сэтгэл хөдлөлөө удирдах, аливаа зүйлд зорилго

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

тавьж, тууштай байх, бусдыг ойлгох зэрэг чадварыг хөгжүүлэх, насан туршдаа суралцахуйг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамтын ажиллагаа, түншлэлээр дэмжиж хөрөнгө оруулалт хийх;

10. Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, их, дээд сургууль, коллежид элсэгч болон төгсөгчдийн үр чадварыг үнэлэхэд ажил олгогчдын оролцоог хангаж, үр чадварыг хөгжүүлэх, баталгаажуулахад хамтран ажиллах;

Тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй сургууль

11. Үндэсний хэмжээнд сургуулийн менежментийн чадварыг дээшлүүлэх (сургууль, сургалтын байгууллагын бүхлээр ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх);
12. Сургуулийн бие даасан байдлыг дэмжиж, шийдвэр гаргахад суралцагч, эцэг эх, олон нийтийн оролцоог ханган саналыг тусгах, түншлэл, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, нөөцийг үр ашигтай ашиглах замаар тэгш хүртээмжтэй, эрүүл, аюулгүй суралцахуйн орчныг эрс сайжруулах;
13. Материаллаг болон сэтгэл зүйн орчны хувьд суралцагчдад суралцах, хөгжих таатай, ээлтэй орчныг цогцоор бүрдүүлэх, ялангуяа суралцагчдын нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үйлчилгээнд анхаарал хандуулах, эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх;
14. Суралцагч бүрд ямар ч нөхцөл байдалд насан туршдаа боловсрол эзэмших боломжийг олгохуйц байх нөхцөлийг бий болгох;

Дижитал суралцахуй

15. Сургалтын нээлтэй нөөцийг хөгжүүлэх, нэгдсэн сан бүрдүүлэх, боловсролын платформыг хөгжүүлэн нэвтрүүлэх, тэдгээрийг ашиглах нээлттэй, тэгш боломжийг (үнэ төлбөргүй) хангах;
16. Хүртээмжтэй, дижитал хуваагдлаас сэргийлсэн, уян хатан, аюулгүй байдлыг хангахуйц тоног төхөөрөмж, өндөр хурдтай найдвартай сүлжээ, дэд бүтцийг бий болгож, хөгжүүлэх;

Боловсролын санхүүжилт

17. Боловсролын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд олон талын оролцоог хангах, санхүүжилтэд инновацыг нэвтрүүлэх, хяналт бий болгох;
18. Аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагаас боловсролд хөрөнгө оруулахтай холбоотой төрөөс үзүүлэх хөшүүрэг, дэмжлэгийг нэмэгдүүлэх, хамтран ажиллах;
19. Боловсролын чанарыг сайжруулах, багшийн хөгжилд зориулсан олон талын санхүүжилтийн санал санаачилгыг нэмэгдүүлэх;
20. Боловсролын төсөв, төлөвлөгөөг ялгаварлан гадуурхалгүй, тэгш боломжоор хангасан, зорилтот стратегиар боловсруулж, хэрэгжүүлэх;

---oOo---

ISBN 9919-9714-7-2



9 789919 971472